7	Сайхан	Хүрэмтийн хөндий	102°38'43.1"	48°40'04.9"
8	Сэлэнгэ	Ихэт ингэтийн тал	103°55'35.6"	49°27'04.5"
9	Тэшиг	Сумын төв	102°37'46.6"	49°56'43.5"
10	Хишиг-Өндөр	Наадмын хөндий	103°26'22.5"	48°19'13.4"

Ерөнхий зориулалтын нисэх онгоц хөөрөх, буух зурвасыг төлөвлөхдөө зурвас, хамгаалалтын бүс нийлээд 10 га байхаар тооцон төлөвлөсөн. Хэрэгжүүлэх хугацааны хувьд агаарын тээврийн салбарын хөгжил манай улсын хэмжээнд төдийлөн хөгжөөгүйн дээр өртөг өндөртэй тул нийт төлөвлөлтийн хугацаагаар тооцон гаргасан.



Зураг 101. Агаарын тээврийн газрын төлөвлөгөө.

2.4. ОЙН САНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Булган аймгийн ойн сангийн газрыг төлөвлөхдөө “Тэр бум мод” үндэсний хөтөлбөр, улсын газар зохион байгуулалтын, ерөнхий төлөвлөгөө, аймгийн засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр болон орон нутгийн саналыг үндэслэн төлөвлөсөн.

Булган аймгийн газрын нэгдмэл сангийн шинэчилсэн бүртгэлээр 1.4 сая.га ойн сан бүхий газар тоологдсон байна. Үүнд тусгай хамгаалалттай газар болон улсын хилийн зурвас газрын ойн сангийн газар тоологдоогүй. Аймгийн хэмжээнд нийт ойн сангийн газрыг тооцон үзвэл 1.9 сая.га газар байна.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд ойн сангийн газрыг төлөвлөхдөө ойн арга хэмжээний төлөвлөгөө, ойжуулалт хийх газрын төлөвлөгөө, ойн нөхөрлөлд олгох газрын төлөвлөгөөг боловсруулан гаргасан.

2.4.1. ОЙН САНГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ойн аж ахуйн арга хэмжээнд мод, сөөгийн үр, боргоцой бэлтгэх, боловсруулах, чанарын шинжилгээ хийх, тарьц, суулгац ургуулах, ойжуулалт, ой нөхөн сэргээлт, хамгаалалтын ногоон зурвас, модлог ургамлын цэцэрлэг байгуулах, ой зохион байгуулалт, ойн дагалт баялаг ашиглах, хөнөөлт шавж, өвчин, түймрээс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх зэрэг ажлууд орно.

Ой зохион байгуулалтын ажлын нэг зорилго нь ойн талбай, нөөц, бүрэлдэхүүн, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг судалж тогтоосны үндсэн дээр ойн санд хэрэгжүүлэх шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж өгөх явдал юм.

Булган аймгийн ойн сангийн газрын төлөвлөгөөг боловсруулахдаа одоогийн ойн сан, ой зохион байгуулалтын ажилтай уялдуулан боловсруулсан. Ойн сангийн газрын

өөрчлөлтөөс харахад ой хээрийн түймэр, хөнөөлт хортон шавж өвчнөөс шалтгаалан ой сангийн газар их хэмжээгээр доройтож байна. Иймд ойн арга хэмжээний төлөвлөгөөнд ойн хөгжлийн төвийн мэдээллийн санд үндэслэн ойн түймрээс сэргийлэх, ойн хортон шавжтай тэмцэх арга хэмжээг төлөвлөсөн.

2.4.1.4. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх арга хэмжээний төлөвлөлт

Ойн аж ахуйн арга хэмжээний салшгүй нэг хэсэг нь ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил юм. Ойг хөнөөлт шавжаас хамгаалах ажлын зорилго нь ойн хөнөөлт шавжийн тархалт, зүйлийн бүрэлдэхүүн, гол хөнөөл учруулж буй шалтгааныг тогтоосны үндсэн дээр тэмцлийн ажлыг технологийн дагуу нарийн хяналттай гүйцэтгэх явдал юм. Эрдэмтдийн судалгаагаар манай улсад 700 гаруй зүйлийн хөнөөлт шавж тэмдэглэгдээд байгаагаас 7 баг, 56 овог, 168 төрөл, 400 орчим зүйлийн шавж жил бүр их, бага хэмжээгээр ойд хөнөөл учруулж байна. Эдгээрээс их хэмжээний газар нутаг хамран тархсан Сибирийн хүр, Якобсоны төөлүүрч, Бургасны бийрэн сүүлт, Энгийн бийрэн сүүлт, Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэй, Шинэсний холтосч том цох, Алтайн ба нарийн сахалт эвэрт цох, Шинэсний урын ялаа, Зургаан шүдэт холтосч цох, Нарсны мөлгөр цох, Нарсны үрийн давирхайч, Сибирийн хатан ногоон жулга, Шинэсний шөвгөр хошуут зэрэг 40 гаруй зүйлийн онцгой аюулт гоц хөнөөлт шавж Хангай, Хэнтий, Хөвсгөл, Алтайн уулархаг мужийн аль их ойтой хэсэгт нэлээд хэмжээгээр тархаж чийг, хур тунадсаар дутмаг, хуурайшилт ихтэй жил богино хугацаанд үй олноороо үржин их хэмжээний ой модыг хөнөөн сүйтгэсээр байна.

Булган аймгийн ойн санд навч, шилмүүсний хөнөөлт шавжийн зүйлийн бүрэлдэхүүн, тархалтын цар хүрээ, биологи-экологийн онцлогийг тогтоох судалгааны ажлыг 2012-2018 онуудад жил бүр хавар намрын улиралд 2 удаагийн давтамжтайгаар явуулж байсан. Одоогийн байдлаар Булган аймгийн ойн санд ойн хөнөөлт шавжийн нөлөөгөөр доройтолд орсон 32.2 мян.га талбай бүртгэгдсэн байна.

Ойн хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээг урьдчилан сэргийлэх, тэмцэх гэсэн 2 хэлбэрээр явуулдаг. Ойн хөнөөлт шавжийн хэт олшролт, хөнөөлийн байдал зэргийг цаг алдалгүй тооцоолж мэдэх, улмаар цаашдын арга хэмжээг төлөвлөх, тэмцлийн ажлыг зохион байгуулахад судалгааны арга чухал ач холбогдолтой байдаг.

Ойн хөнөөлт шавжийн судалгааг дотор нь ажиглалт, тоймчилсон, нарийвчилсан судалгаа гэж ангилна. Манай орны ойн аж ахуйн практикт эдгээр судалгааг хэрэгжүүлэх нь ойг хөнөөлт шавжаас хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд чухал юм.

Ажиглалт судалгааг ойн хөнөөлт шавж, өвчний тархалт, голомт үүсэж болзошгүй ойг байнгын хяналтдаа авч байх зорилгоор орон нутгийн байгаль орчны мэргэжилтэн, инженер, техникч, байгаль хамгаалагч нар гүйцэтгэж хөнөөлт шавж, өвчин илэрсэн нөхцөлд мэдээлэл өгнө.

Орон нутгаас ирсэн мэдээллийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-аас шуурхай арга хэмжээ авч ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Тоймчилсон судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд хуурайшилт, ойн түймэр зэргээс шалтгаалан хөнөөлт шавж, өвчний хуучин голомтууд сэргэн тархалт тэлэгдэх хандлагатай байна. Судалгааны ажлыг ойн хөнөөлт шавж, өвчний хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэхийн тулд жил бүр зохион байгуулах шаардлагатай.

Нарийвчилсан судалгааг ойн зонхилогч хөнөөлт шавжийн биологийн онцлог шинж, тархалтын цар хүрээ, олшролын үе шатыг тогтоон улмаар ойн хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээг өөрийн орны цаг уурын онцлогт тохируулан боловсруулах зорилгоор явуулдаг.

Манай орны хувьд хөнөөлт шавжийн үржин олширч, хор хөнөөл учруулах экологийн нөхцөл харьцангуй өндөр байгаа юм.

Судалгаанаас үзэхэд ойн хөнөөлт шавж нь гол төлөв 10-30 хэмийн налууд ургасан 16-20 метр өндөр, 20-28 см диаметртэй, IY-Y бонитетийн, 0.5-0.6 өтгөрөлтэй шинэсэн ойд үлэмж хэмжээгээр тархан хохирол учруулж байна. Ойг хөнөөлт шавжаас хамгаалах ойн аж ахуйн арга хэмжээ нь ойг хамгаалах үндсэн арга юм.

Булган аймгийн нийт ойн сангийн газрын 1.7 хувь нь хөнөөлт шавж, хортон тархсан байна. Сумдаар авч үзвэл Гурванбулаг, Орхон, Сайхан сумдын ойн сангийн газрын 13-27 хувь нь хөнөөлт шавж, хортон тархсан байна.

Хүснэгт 98. Ойн хөнөөлт шавж, хортон тархсан газар


№	Сумын нэр	Ойн сан бүхий газар, га	Хөнөөлт шавж, хортонд тархсан газар, га	Эзлэх, %
1	Баян-Агт	77,806.5	3,076.6	4
2	Баяннуур	783.8		
3	Бугат	191,960.4	248.3	0.1
4	Булган	594.0		
5	Бүрэгхангай	25,451.8	1,467.2	5.8
6	Гурванбулаг	2,816.9	782.4	27.8
7	Дашинчилэн	112.5		
8	Могод	30,014.7	1,424.7	4.7
9	Орхон	78,384.4	10,451.7	13.3
10	Рашаант	3,844.1	358.4	9.3
11	Сайхан	14,665.2	2,027.1	13.8
12	Сэлэнгэ	399,167.9		
13	Тэшиг	649,766.3	3,754.8	0.6
14	Хангал	110,199.3	136.9	0.1
15	Хишиг-Өндөр	33,643.0	438.0	1.3
16	Хутаг-Өндөр	304,699.4	8,073.0	2.6
НИЙТ		1,923,910.2	32,239.2	1.7

Судалгаагаар тогтоогдсон хөнөөлт шавжийн тархалтыг хязгаарлах, хөнөөлийг багасгах, голомтыг арилгах зорилгоор тэмцлийн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тэмцлийн арга хэмжээг гүйцэтгэх аргыг дотор нь агротехник, хими, биологи, физик-механик, хорио цээрийн гэж ангилна.

- Агротехникийн буюу агро экологийн арга нь тарьц, суулгацыг ургуулах үед хөнөөлт шавжид тохиромжгүй нөхцөл бүрдүүлж, ургамлын өсөлт хөгжилтөд тохиромжтой нөхцөлийг бий болгоно. Энэ аргыг мод үржүүлгийн газарт болон ойжуулалтын ажлын үед хэрэглэдэг. Тархсан хөнөөлт шавжийн зүйл ангийг тогтоосны үндсэн дээр дээрх ажлыг явуулна.
- Химийн арга нь ихэвчлэн янз бүрийн химийн бодисыг ашиглан их хэмжээгээр гарч ирсэн хөнөөлт шавжийг богино хугацаанд тархалтыг хязгаарлахад зориулагдана. Одоогоор химийн аргыг хэрэглэхээс нийтээр татгалзаад байна.
- Физикийн арга нь цахилгаан энерги, их бага температур, өндөр хүчдэл зэргийг хэрэглэн хөнөөлт шавжийн орчныг хувиргах юм уу хөнөөлт шавжийг шууд устгах зориулалттай байдаг.
- Механик арга нь янз бүрийн механик ажиллагаагаар хөнөөлт шавжтай тэмцэх явдал юм. Жишээлбэл: цох баригч, хүрэнцэр баригч, наалдуулах бүслүүр гэх мэт.
- Биологийн арга нь хөнөөлт шавжийн байгалийн дайсан паразит ба махчин шавж идэштэн шувуу, сүүн тэжээлтэн, шавжид өвчин үүсгэгч нян вирус, мөөг мэтийг хэрэглэн тэмцэх юм.

- Хорио цээрийн арга хэмжээ нь аюултай хөнөөлт өвчин, шавжийг гадаад орноос өөрийн оронд нэвтрүүлэхгүй байх, орон нутаг дотор нөгөөд тархаахгүй байх арга хэмжээ орно. Манай оронд ойн навч, шилмүүсний хөнөөлт шавжтай тэмцэхэд хими, механик, биологийн аргыг хэрэглэдэг. Үндсэн голомт илэрсэн нутгуудад суурин ба нарийвчилсан судалгааг явуулж хөнөөлт шавжийн тоо толгойн хэлбэлзэл, улирлын ба хоногийн идэвх, хөгжлийн үе шатыг нарийвчлан тогтоож цаашид дэс дараалалтай тэмцэл хийх зохион байгуулалтын арга хэмжээний төсөл төлөвлөгөө боловсруулна. Юуны өмнө хөнөөлт шавжийн хөгжлийн үе шат, өсөх буурах хандлага, ашигтай шавжийн үйлчилгээний хэмжээ, цаг уурын урьдчилсан мэдээ, хүйсийн харьцаа зэрэг чухал үзүүлэлтийг тогтоосны үндсэн дээр дараагийн жилүүдийн тэмцэх ажлын төлөвлөгөөг боловсруулна. Аймаг, сумын засаг дарга нар ойн хөнөөлт шавж өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хөтөлбөр боловсруулж түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгаж байх хэрэгтэй.

Аймгийн хэмжээнд төлөвлөлтийн хугацаанд ойн хөнөөлт шавж, хортон тархсан газарт түүнтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн.



Зураг 102. Ойн хөнөөлт шавж, хортонтой тэмцэх газрын төлөвлөгөө

2.4.1.5. Ойн түймэртэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө

Монгол орны ойн экосистемд сөрөг нөлөө үзүүлдэг томоохон хүчин зүйл нь ой хээрийн түймэр юм. Иймээс ойн санд ихээхэн хэмжээний экологийн болон эдийн засгийн хохирол учруулж байгаа ойн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Ойг түймэрт өртөх байдлыг харгалзан шаталтын зэрэг тогтоодог. Ой, хээрийн түймрийн шаталтын зэрэглэлийг зөв тогтоох нь түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх,

түүнтэй тэмцэх, учирсан хохирлыг тооцох, шуурхай арилгах, шатсан ойг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлого боловсруулж хэрэгжүүлэх үндэслэл болдог.

Түймрийн эрчмийг тодорхойлохдоо нэг талаас модны гэмтлийн зэрэг нөгөө талаас галын ул мөрийг тооцоолон сул, дунд, хүчтэй, нэн хүчтэй эрчимтэй гэсэн 4 бүлэгт хувааж тус бүрийнх нь хамарсан талбай модны төрлийг тогтооно.

Сул эрчимтэй түймэрт өвслөг болон сөөглөг ургамлын ихэнх хувь нь шатахаас гадна 1 метр хүртэлх өндөртэй зулзаган модод өртдөг. Түймэрт нэрвэгдсэн ойн талбайн модны нөөцийн 15 хүртэл хувь цаашид ургах боломжгүй шатсан ой хамаарна.

Дунд эрчимтэй түймэрт дээрх өвслөг, сөөглөг ургамал, зулзаган моддоос гадна 5-6 метр хүртэлх өндөртэй ширэнгэ, том моддын титмийн өндрийн хагас хувь хүртэл шатдаг байна. Модны нөөцийн 16-45 хувь шатсан ой хамаарна.

Хүчтэй эрчимтэй түймэрт өвслөг, сөөглөг ургамал, зулзаган мод, ширэнгэн ташинга шатахаас гадна модны нөөцийн 46-45 хүртэл хувь шатсан ойн талбай хамаарна.

Нэн хүчтэй эрчимтэй түймэрт том мод оройгоо хүртэл шатаж мөхдөг байна. Модны нөөцийн 75-аас дээш хувь нь шатсан ойн талбай хамаарна.

Ойн түймрийн шаталтын зэрэглэлийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны 106 дугаар тушаалаар батлагдсан “Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ыг баримтална.

Булган аймгийн хэмжээнд түймэрт өрсөн нийт ойн сангийн 11.5 хувь буюу 221.7 мян.га ой модоор бүрхэгдсэн газар түймэрт өрсөн байна. Энэхүү түймэрт өрсөн газрыг нөхөн сэргээж ойжуулах, цэвэрлэгээний мод огтлолт хийхээр төлөвлөгөөнд тусгасан. Ой хээрийн түймэрт өртсөн газрыг төлөвлөх боломжгүй тул урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтийг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусган ажилласан.

Орон нутгийн удирдлага ойн түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллах нь ойн түймрээс сэргийлэхэд нэн чухал ач холбогдолтой юм.

Түймрийн аюултай үе болох жил бүрийн 3 сарын 20-ны өдрөөс 6 сарын 10-ны өдөр, 9 сарын 20-ны өдрөөс 11 сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд ил задгай гал түлэхгүй байх, зайлшгүй тохиолдлоор түлсэн гал, асаасан чүдэнз, татсан тамхины гал, цог нурмыг бүрэн унтраах.

Ойн түймрээс урьдчилан сэргийлэх: Гал түймрийн аюултай үед ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, аялал зугаалгаар явах, бусад ажлыг гүйцэтгэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагчид мэдэгдэж гал түймэр гаргахгүй байх талаар баталгаа өгөх.

Ойн гал түймрийг илрүүлсэн, гал түймрийн тухай мэдээ хүлээн авсан бол сумын болон багийн засаг дарга нар өөрийн хүч хэрэгслийг зохион байгуулан бага дээр нь даруй унтраах арга хэмжээ авах, холбогдох байгууллагад мэдэгдэх. Ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлж, ухуулга, сурталчилгааны ажлыг эрчимтэй явуулах.

Харлуулсан зурвас татах: Түймрийн аюул ихтэй залуу, зулзаган мод бүхий галын онц аюултай объектын дагуу 1-2.5 метр өргөн түймрийн хамгаалалтын харлуулсан зурвас татна.

Харуулын цамхаг байгуулах: Энэ нь ойд гарсан түймрийг илрүүлэх зорилгоор тухайн газар нутгийн байдлыг ажиглахын тулд хийгддэг өндрийн байгууламж юм. Ийм цамхгийг мод ба төмрөөр хийнэ. Ойн түймэр их гардаг түймрийн аюул ихтэй газруудад түймрийн цамхаг босгох хэрэгтэй. Уулын биш харьцангуй тэгш газрын ой доторх цамхгийн өндөр 25-35 метр байх хэрэгтэй.

Харин уулын ойд нутаг дэвсгэрийн хамгийн өндөрлөг цэг дээр 10 метр хүртэл өндөртэй цамхаг байгуулна. Цамхаг хоорондын зай ойролцоогоор 10-12 км буюу 10-20 мянган га талбай тутамд 1 цамхаг байвал тохиромжтой. Ажиглалтын цамхагт газар нутгийн схем зураг, холбооны хэрэгсэл, дуран, цаг бүртгэлийн дэвтэр зэрэг байна.

Машин ба морин эргүүл: Түймрийн аюултай хавар, намрын хуурайшилтын үед зам харилцааг судалсны үндсэн дээр чиглэл чиглэлд тусгай маршрут гарган машин болон морин эргүүл ажиллуулах нь чухал юм.

Сурталчилгааны ажил: Хүн ам ихээр суурьшсан газар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлсэн анхааруулга, сэрэмжлүүлэг, сурталчилгаа бүхий самбар хийж байрлуулах нь чухал юм.

-Зөвлөмж, санамж хэвлэж тараах

-Түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, семинар зохион байгуулах

-Түймрээс урьдчилан сэргийлэх сурталчилгааг хүн бүрд хүргэж түймэртэй тэмцэх бэлтгэлийг хангуулах хэрэгтэй.

-Ой хээрийн түймэртэй тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслээр хангагдах хэрэгтэй.

Түймрийг илрүүлэх арга: Хавар намрын гал түймрийн аюултай үед байнгын жижүүр, морин болон машин эргүүл гаргаж тэднээс болон ард иргэдээс ойн түймэр илрүүлсэн тухай мэдээ авсан тохиолдолд сум, багийн засаг дарга богино хугацаанд хүн хүчийг зохион байгуулж түймрийг унтраах, холбогдох байгууллагад яаралтай мэдээлэх хэрэгтэй.

Түймрийг унтраах арга хэмжээ: Түймрийн мэдээг хүлээн авсан засаг дарга нь өөрийн эрхийн хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг зохион байгуулж түймэр унтраах төлөвлөгөө, шийдвэр гаргасан байна.

Түймэр унтраахад түймрийн тархалтыг зогсоох, цурванд оруулах, цурванд оруулсан галыг унтраах, цурваас дахин гал гарахаас сэргийлж харуул манаа ажиллуулах гэсэн үе шатаар тэмцэх хэрэгтэй.

Түймрийн тархалтыг зогсоох: Энэ үе шат нь шаталтын дөлийг цохиураар цохих, шороо, ус цацах, цурванд оруулах гэх мэт олон янзын аргаар түймрийн давшилтыг зогсооно.

Түймрийг тусгаарлах буюу цурванд оруулах: Түймрийн дөлийг зогсоосны дараа шатсан талбайг тойруулан 0.3-0.5 метр өргөн харлуулсан зурвасаар түймрийг тусгаарлана.

Цурванд оруулсан галыг унтраах: Хамгаалах зурвас татсаны дараа цурав дотор шатаж байгаа мод, хожуул, бут, сөөг зэрэг галын эх үүсвэрийг цурвын захаас эхлэн төв рүү нь гал унтраагч багаж, хүрз болон бусад гар багажаар унтраана.

Түймрийг дахин сэргэхээс сэргийлж харуул, манаа тавих: Энэ нь шатсан талбайн захаар 10 метр орчим өргөн газарт хяналт тавьж зурвас давж унасан оч, галыг унтраана.

2.4.1.6. Ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө


Булган аймаг нь Бүрэнгийн нуруу, Эрчимийн нуруу, Бүтээлийн нурууны өврийг эс тооцвол үндсэндээ бие биеэс тусгаар, уулын арыг барьж ургасан тасархай ойтой. Хүн ам харьцангуй нягт суурьшсан болохоор түймрийн нөлөө ихтэй. Тиймээс ч мод огтлолт болон түймрийн дараа шилмүүст модны оронд хус улиангар зэрэг навчит мод орлон хурдан ургадаг.

Ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээний зорилго нь ойн нөөцийг арвижуулах, ойн удмын санг хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, ойн хамгаалалтын ач холбогдлыг алдагдуулахгүй байх явдал юм. Үүний тулд ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн болон мод бэлтгэсэн талбайд нэн түрүүнд мод тарьж ургуулах, нөхөн сэргээх ажлыг хийх

хэрэгтэй. Ойг нөхөн сэргээх арга хэмжээг зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтад туслах гэсэн 2 хэлбэрээр хийдэг.

Ойжуулалт: Ойд их хэмжээний талбайг хамруулан огтлолт хийснээс болон түймрийн улмаас хөрсний гадаргын температур өндөр болж, хөрсний өнгөн хэсгийн чийгийн хангамж үлэмж хэмжээгээр багасах, өвслөг ургамал ихээр урган өсвөр ургац шинээр гарч ирэхэд саад учруулснаас ойн сэргэн ургах үйл явц удааширч бараг ахиж сэргэхгүй байдалд хүрдэг. Иймд ширэгжилд явагдахаас өмнө зориудаар ойжуулах ажлыг гүйцэтгэх хэрэгтэй байдаг.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ажлын хүрээнд ойжуулалт хийх талбайг тогтоосон бөгөөд энд тармаг модтой талбай, шатсан талбай, мод бэлтгэсэн талбай хамаарна. Ойжуулалт хийх ойн газрыг төлөвлөхдөө байгалийн аясаар сэргэн ургалт явагдаагүй буюу хангалтгүй ургалттай мод бэлтгэсэн болон шатсан талбайг сонгон ойжуулалт хийхээр төлөвлөсөн. Булган аймгийн 10 сумын ойн сангийн хэмжээнд 28.3 мян.га талбайд ойжуулалт хийхээр төлөвлөн ажилласан.




Диаграмм 6. Ойжуулалт хийх газрын төлөвлөгөө, сумдаар

Эдгээр газарт үндсэн төрлийн шилмүүст, навчит ойг зориудаар нөхөн сэргээх шаардлагатай. Мод бэлтгэсэн, түймэрт шатсан газрыг ойжуулах ажлыг тайгажуу бүслүүрийн шинэсэн ойн үндсэн хэв шинжүүдэд шинэсний 3 настай тарьцаар, 9 дүгээр сараас эхлэн 10 дугаар сарын эхний 10 хоногт багтаан гүйцэтгэх хэрэгтэй. Тайгархаг бүслүүрийн шинэсэн ойн мод бэлтгэсэн, түймэрт шатсан газарт мөн шинэсний 3 настай тарьцаар ойжуулах ба тарьцыг хавар суулгахад бусад хугацаанаас илүү сайн үр дүн өгнө. Тайгархаг бүслүүрийн нарсан ойн мод бэлтгэсэн, түймэрт шатсан талбайг ойжуулахад мод үржүүлгийн газрын ил хөрсөнд болон хүлэмжид ургуулсан нарсны 2 настай тарьцыг шилжүүлэн суулгана. Ойжуулалтад зориулж хөрс боловсруулж, үр тарьц суулгах ажлыг хуурайсаг-элдэв өвст тайгархаг болон тайгажуу бүслүүрийн ойн нөхцөлд 0.7 метр өргөн, 8-10 см гүн зурвас шангийн ёроолд, нугын элдэв өвст тайгархаг ойн хэв шинжүүдэд 1.0-1.2 метр өргөн, 8-10 см гүн зурвас шангийн ёроолд, тайгын бүслүүрт 0.8 метр өргөнтэйгөөр хөрсний 8-10 см үеийг байранд нь эргүүлэн сийрүүлж зурваслан боловсруулсан хөрсөнд тус тус гүйцэтгэх шаардлагатай. Мод бэлтгэсэн, шатсан газрын орчны өөрчлөгдлийг нарийн тооцож ойн өндрийн бүслүүрүүдэд ойжуулалтын ажлыг өвөрмөгц арга, технологиор явуулах нь уг ажлын эцсийн дүнг дээшлүүлж, өндөр бүтээмжтэй ойг хугацаа алдалгүй ургуулах боломжтой.

Булган аймгийн хэмжээнд нийт ойн сангийн газрын 1.5 хувь 28.3 мян.га газрыг ойжуулахаар төлөвлөсөн. Нийт ойн санд тусгай хамгаалалттай болон улсын хилийн зурвас газрын ойн хамруулан тооцсон.

Хүснэгт 99. Ойжуулалт хийх газрын төлөвлөгөө

№	Сумын нэр	Ойн сан бүхий газар, га	Ойжуулалт хийх талбай, га	Нийт ойн санд эзлэх, %
1	Баян-Агт	77,806.5	2,991.8	3.8
2	Баяннуур	783.8		
3	Бугат	191,960.4	3,706.6	1.9
4	Булган	594.0		
5	Бүрэгхангай	25,451.8	344.0	1.4
6	Гурванбулаг	2,816.9		
7	Дашинчилэн	112.5		
8	Могод	30,014.7	72.2	0.2
9	Орхон	78,384.4	2,923.9	3.7
10	Рашаант	3,844.1		
11	Сайхан	14,665.2	263.8	1.8
12	Сэлэнгэ	399,167.9	8,608.4	2.2
13	Тэшиг	649,766.3	3,303.4	0.5
14	Хангал	110,199.3	4,461.6	4
15	Хишиг-Өндөр	33,643.0	773.8	2.3
16	Хутаг-Өндөр	304,699.4	850.6	0.3
НИЙТ		1,923,910.2	28,300.0	1.5




Зураг 103. Ойжуулах газрын төлөвлөгөө

Ойн байгалийн сэргэн үргалтад туслах арга хэмжээ: Мод бэлтгэсэн, ойн түймэр, хөнөөлт шавжид нэрвэгдсэн ойд үлдсэн болон түүний зэрэгцээ ойгоос үр цацагдах буюу хожуулаас ургал эрхтнээр дахин ой бий болох явцыг ойн байгалийн сэргэн ургалт гэх бөгөөд байгалийн аясаар сэргэх боломжгүй газарт ойг нөхөн сэргэхэд үзүүлэх хүний

зориудын дэмжлэгийг ойн байгалийн сэргэн ургалтад туслах ажил гэнэ. Энэ ажлыг дараах хэлбэрээр явуулна. Үүнд:

- Ойн зах, мод бэлтгэсэн, шатсан талбайд модны цухуйлц өсөж томроход өвслөг ургамлын өрсөлдөөнийг арилгах зорилгоор анжсаар шан татах. Ийм газарт модны үр байгалийн аясаар унаж чөлөөтэй ургах нөхцөл бүрдүүлэх;
- Мод бэлтгэсэн, шатсан талбайд гараар үр цацаж орхих;
- Мод бэлтгэсэн, шатсан талбайд гар аргаар 40x40 см-ээс 1x1 метр хэмжээтэй талбарын ширэг бүхий хөрсний өнгөн хэсгийг хуулж модны үр цацах буюу байгалийн аясаар үр унаж ургах нөхцөлийг бүрдүүлэх;
- Хөгшин мод ихтэйгээс тэжээлийн талбай хүрэлцээгүй болж ойн дараачийн үр удмыг бүрдүүлэх цухуйлц зулзаган мод гарч ирэхгүй үед хөгшин модноос тодорхой хэмжээний цэвэрлэгээний огтлолт хийх;
- Дунд насны шигүү модонд сийрэгжүүлэх арчилгаа хийх замаар дараагийн насны ойн байгалийн сэргэн ургалтад туслах;
- Мод бэлтгэлийн талбайд үрийн мод үлдээх нь ойн сэргэн ургалтад туслах ажлын нэг чухал хэсэг;
- Хөрсний гадаргууг хагалан бэлтгэх. Үр тархан ургах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд их үрийн жилийг угтуулан хөрсийг хагалан боловсруулах;



Диаграмм 7. Ойн байгалийн сэргэн ургалтад туслах газар, нийт ойн санд эзлэх хувь


Булган аймгийн хэмжээнд нийт ойн сангийн 0.7 хувь буюу 14.1 мян.га газарт ойн байгалийн сэргэн ургалтад туслахаар төлөвлөсөн.

Хүснэгт 100. Байгалийн сэргэн ургалтад туслах ойн газрын төлөвлөгөө

№	Сумын нэр	Ойн сан бүхий газар, га	Ойн байгалийн сэргэн ургалтад туслах газар, га	Нийт ойн санд эзлэх, %
1	Баян-Агт	77,806.5	144.7	0.2
2	Баяннуур	783.8		
3	Бугат	191,960.4	2,087.9	1.1
4	Булган	594.0		
5	Бүрэгхангай	25,451.8		
6	Гурванбулаг	2,816.9	840.4	29.8
7	Дашинчилэн	112.5		
8	Могод	30,014.7	479.9	1.6
9	Орхон	78,384.4	1,018.2	1.3
10	Рашаант	3,844.1	0.4	0.01

11	Сайхан	14,665.2	885.9	6
12	Сэлэнгэ	399,167.9	2,331.9	0.6
13	Тэшиг	649,766.3	2,150.7	0.3
14	Хангал	110,199.3	2,524.1	2.3
15	Хишиг-Өндөр	33,643.0	85.9	0.3
16	Хутаг-Өндөр	304,699.4	1,586.6	0.5
НИЙТ		1,923,910.2	14,136.4	0.7

Ойн байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлын гол зорилго нь ойн түймэр, ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай болон мод бэлтгэсэн талбайн ойн орчны нөхцөл өөрчлөгдөхөөс өмнө уг ойн аясаараа сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм.



Зураг 104. Ойн байгалийн сэргэн ургалтад туслах арга хэмжээний төлөвлөгөө

2.4.2. ОЙ АШИГЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д ой, амьтан, ургамал зэрэг байгалийн нөөц баялгийг судлах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй цогц байдлаар шийднэ гэж заасан байдаг. Иймд ойн сангийн газрыг хамгаалахаас гадна зохистой ашиглах төлөвлөгөө боловсруулан төлөвлөсөн.

Булган аймгийн ойн сангийн газрын “Ойн тухай хууль”-ийн дагуу ашиглалт, хамгаалалтын бүсийн ой гэж ангилдаг. Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баян бүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна.

Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Ашиглалтын бүсийн ойд хамгаалалтын бүсэд хамрагдаагүй үлдсэн бүх ойг хамааруулна. Ашиглалтын бүсийн ойгоос иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, мод бэлтгэх, ойн дагалт нөөцийг тусгасан менежментийн төлөвлөгөөний дагуу ашиглах эрхтэй. Булган аймгийн ойн сангийн 13.6 хувь буюу 258941.7 га талбай ашиглалтын бүсийн ойд хамаарч байна.

Хүснэгт 101. Ойн ашиглалт, хамгаалалтын бүс

№	Ойн бүс	Талбай, га	Эзлэх, %
1	Хамгаалалтын бүсийн ой	1,647,625.8	86.4
2	Ашиглалтын бүсийн ой	258,941.7	13.6
НИЙТ		1,906,567.5	100

Ойн ашиглалтын бүсэд ойн ашиглах нөөц тогтоосноор түүнд үндэслэн мод огтлолтын ажлыг ой зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан явуулдаг. Булган аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд ашиглалтын бүсийн ойд арчилгаа болон цэвэрлэгээний мод огтлолт явуулах төлөвлөсөн.

Ойн аж ахуйн нэгэн чухал арга хэмжээ нь цэвэрлэгээний огтлолт юм. Ойн цэвэрлэгээ гэж ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх замаар ойг хамгаалах, ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээ юм.

Ойн цэвэрлэгээ нь ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг ойгоос гаргах, ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэж хатсан цаашид ургах чадваргүй болсон ойн модыг огтлох замаар ойг цэвэрлэх, ойг эрүүлжүүлэхэд чиглэгдсэн цэвэрлэгээний огтлолт хийх гэсэн 2 төрлөөр хийгддэг.

Ойн цэвэрлэгээг ашиглалтын болон хамгаалалтын бүсийн суларч доройтсон, хатсан модтой бүх насны ойд хийнэ. Ойн цэвэрлэгээний үед “Ойн цэвэрлэгээний болон үндсэн ашиглалтын огтлолт, арчилгаа, цэвэрлэгээнд тавигдах ерөнхий шаардлага” стандартыг мөрдөнө.

Цэвэрлэгээний ажлаар түймэр, хөнөөлт шавж, салхи, цасны нөлөөгөөр их хэмжээгээр унасан мод, үзүүр, ёзоор, мөчир гишүүг авч ойг цэвэрлэнэ. Цэвэрлэгээний

ажлын үед унасан модны 30 хувийг талбайд үлдээж ойн амьтан, бичил организмын амьдрах орчин бүрдэх нөхцөлийг хангана.

Ойн цэвэрлэгээний огтлолтыг түүвэрлэн огтлох, харьцангуй хавтгайруулан огтлох гэсэн 2 хэлбэрээр явуулна.

Цэвэрлэгээний түүвэрлэн огтлолт нь ойн эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах зорилгоор өвчин, хөнөөлт шавжид нэрвэгдэж доройтсон, хатаж байгаа болон хатсан модыг түүвэрлэн авах огтлолт юм.

Цэвэрлэгээний харьцангуй хавтгайруулан огтлолт гэж түймэр, хөнөөлт шавж, өвчин, хүчтэй салхи, цас зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлд нэрвэгдэн их хэмжээгээр үхэж, биологийн тогтворт байдлаа алдсан ой модыг бүрэн солих, нэлэнхийд нь ойжуулах зорилгоор хийх огтлолтыг хэлнэ.


Булган аймгийн ойн санд 254158 га талбайд 8168760 м³ хатсан мод, 2697730 м³ унанги мод бүртгэгдсэн байна. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хүрээнд ашиглалтын бүсийн ой бүхий 5 сумын хэмжээнд 398 байршилд 26.1 мян.га талбай ойн түймэр, хөнөөлт шавж, хортон идэгдсэн ойд цэвэрлэгээ, арчилгааны мод огтлолт хийхээр төлөвлөсөн.

Хүснэгт 102. Цэвэрлэгээний огтлолт хийх ойн төлөвлөгөө

№	Сумын нэр	Байршил	Ойн талбай, га
1	Бугат	49	2,828.7
2	Сэлэнгэ	58	10,758.6
3	Тэшиг	182	7,618.7
4	Хангал	90	4,358.5
5	Хутаг-Өндөр	19	609.8
НИЙТ		398	26,174.4

Ойд цэвэрлэгээний ажил хийснээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн хэрэгцээний болон түлшний хэрэгцээг хангах боломжтой. Ойн цэвэрлэгээний ажлыг арчилгаа, цэвэрлэгээний эрх бүхий мэргэжлийн байгууллагаас гадна ойн нөхөрлөл, иргэн гэрээ байгуулан хийж гүйцэтгэнэ. Харин ойн цэвэрлэгээний огтлолтыг зөвхөн арчилгаа, цэвэрлэгээний эрх бүхий ойн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

Тухайн жилд хийх арчилгаа, цэвэрлэгээний ажлын хэмжээг “Ойн менежмент төлөвлөгөө”-г үндэслэн Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл тус бүрээр тогтооно. Аймаг, нийслэлийн Байгаль хамгаалах газар тогтоосон хэмжээнд багтаан тухайн жилд хийх арчилгаа, цэвэрлэгээний ажлын талбай, огтлолтын хэлбэрийг хэсэглэл, ялгарал тус бүрээр сонгож төлөвлөнө.



Зураг 105. Ойн байгалийн сэргэн ургалтад туслах арга хэмжээний төлөвлөгөө

2.4.3. МОД ТАРИХ, ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж байгаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд мод тарих, ойн зурвас байгуулах газруудыг орон нутгийн саналыг үндэслэн төлөвлөсөн. Булган аймгийн тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээгээр нийт газар нутгийн 0.2 хувь ойн сангийн газарт тохиромжгүй бол 52 хувь нь тохиромжтой болон хязгаарлагдмал тохиромжтой байна.

Булган аймгийн хэмжээнд тариалан, бэлчээрийн газрыг салхины эвдрэлээс хамгаалах, элсний нүүдлээс хамгаалах, ус, булгийн эхийг хамгаалах зорилгоор хамгаалалтын ойн зурвас байгуулахаар төлөвлөсөн. Мөн улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон орон нутгийн саналын дагуу мод тарих, таримал ой байгуулах газрыг тусгасан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Булган аймгийн хувьд 20 сая мод тарьж ургуулахаар тусгагдсан. Тус тарих модонд аймгийн хэмжээнд шилмүүст, навчит модноос шалтгаалан 15-20 мян.га талбай шаардлагатай байна. Мод тарих газрыг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон орон нутгийн саналыг үндэслэн аймгийн хэмжээнд 80 байршилд 8653.0 га газарт мод тарихаар төлөвлөж байна.

Хүснэгт 103. Мод тарих газрын төлөвлөгөө

№	Сумын нэр	Байршил	Талбай, га
1	Баян-Агт	2	30.8
2	Баяннуур	6	108.0
3	Бугат	10	2095.2
4	Бүрэгхангай	3	68.7
5	Дашинчилэн	7	802.2
6	Могод	18	1343.7
7	Орхон	5	17.3
8	Рашаант	4	684.5
9	Сайхан	1	23.1
10	Сэлэнгэ	10	316.1
11	Хангал	4	37.9
12	Хишиг-Өндөр	3	2154.5
13	Хутаг-Өндөр	7	971.0
НИЙТ		80	8653.0

Ойн зурвас гэдэг нь байгаль уур амьсгалын нөхцөлийг хүмүүсийн амьдрал, үйлдвэрлэлд ашигтайгаар өөрчлөх зорилгоор ойг тарьж ургуулахыг хэлнэ. Ойн зурвасын ажил нь таримал ойгоос модлог болон бусад бүтээгдэхүүнийг ашиглах зорилгоор бус харин түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг ашиглах чиглэлээр хийгддэгээрээ ойжуулалтын ажлаас ялгарна. Ойн зурвас тодорхой хэмжээний зайд салхины хүчийг өөрчлөн бууруулснаар хөрсний гадаргуу ба ургамлаас ууршин алдагдах чийгийг бууруулна. Үүнээс гадна ойн зурвас нь хөрсний гадаргуугаар цасыг харьцангуй жигд хуваарилж хунгарлуулах тул хөрсийг хөлдөлтөөс хамгаална.

Хамгаалалтын ойн зурвас нь өөрийн үүрэг зориулалтаасаа хамаарч дараах үндсэн хэлбэрүүдэд хуваагдан.

- Талбай хамгаалах ойн зурвас: хуурай халуун салхинаас тариалангийн талбайг хамгаалах, хөдөө аж ахуйн таримал ургамал ургах нөхцөлийг сайжруулах зорилгоор тариалангийн талбай, услалтын системд ойн зурвас байгуулна.

- Ус тохируулах ойн зурвасыг энгэр хажуу налуу газруудад газрын налуугийн хөндлөн чиглэлд байгуулдаг. Энэ зурвасын үндсэн зориулалт нь цас борооны усны урсах хөдөлгөөнийг сааруулж хөрсөнд аль болох ихээр шингээж хөрсийг угаан урсгаж эрэг ганга гарч эвдрэхээс хамгаалах явдал юм.

- Ганга, гуу жалгыг хамгаалах ойн зурвасыг нэгэнт бий болсон ганга жалгыг ихэсгэхгүй байж бэхжүүлэх зорилгоор эрэг гангын налуу хажуу ёроолд хөндлөн чиглэлтэй ойн зурвас байгуулна.

- Усан санг хамгаалах ойн зурвасыг усан сангийн гадаргаас ус уурших, шороогоор дүүрэхээс хамгаалж усан сангийн барилга байгууламжийг бэхжүүлэх зорилгоор байгуулна.

- Услах системийг хамгаалах ойн зурвасыг услагдах талбайг салхины хорт нөлөөнөөс хамгаалах, суваг шуудуу намагжих, хог ургамал ургаж суваг шуудууг таглах эвдлэхээс хамгаалах зорилгоор байгуулна.

- Элс хамгаалах ойн зурвас нь элс бүхий талбайн хэмжээг ихэсгэхгүй байх, элс салхинд үлээгдэж бэлчээр, хадлан тариалан, суурины талбайг дарахаас хамгаалах, элсийг зохистой ашиглах зорилгоор байгуулна.

- Хадлан бэлчээрийн талбай хамгаалах ойн зурвас нь бэлчээр, хадлангийн талбайн ургацыг нэмэгдүүлэх тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байгуулна.

Ойн зурвас байгуулах ажлыг манай орны нөхцөлд тарьц, суулгацаар тэгэхдээ ихэнх тохиолдолд суулгацаар хийх нь үр дүнтэй. Мод үржүүлгийн талбайгаас тарьц суулгацыг навч шилмүүс унаж өсөлт зогссоны дараа болон хавар шүүс хөдлөхөөс өмнө ухаж авна. Намар ухсан тарьц суулгацыг тусгайлан ухсан шуудуунд булж, үртэс сүрлээр хучиж хадгална. Манай орны нөхцөлд тарьц суулгацыг хавар ухаж богино хугацаанд суулгах нь үр дүнтэй. Мод сөөгийг суулгах ажлыг хавар газар гэсэмэгц 5-7 хоногт багтаан шуурхай явуулах нь зүйтэй.

Салхи ихтэй нутгуудад суулгацын үндэсний хүзүүвчийг газрын гадаргуугаас 7-8 см, хавар суулгах тарьцыг 3-4 см, намар суулгах бол 4-5 см дор суулгана. Мод сөөгийг аль болохоор эгнээнд нь тэгш жигд суулгавал үзэмжтэй байхаас гадна арчилгаа явуулахад дөхөмтэй байна.

Ойн зурваст суулгасан мод үхэж хорогдсон тохиолдолд нөхөн суулгалт хийнэ. Суулгалтыг технологийн дагуу хийж арчилгаа шаардлагын дагуу явуулсан үед эхний жилийн амьдралд 100.0 хүрэх тохиолдол ч бий. Иймээс ойн зурваст нөхөн сэргээлт хийх арга хэмжээг 2 дахь жилийн ургалтын байдлаар тооцох нь ашигтай. Ойт хээрийн бүсэд хоёр дахь жилийн намрын тооллогоор суулгасан мод, сөөгний 15.0 хувь хээрийн бүсэд 20 хувь, говь хээрийн бүсэд 25 хувь хүртэлх хэмжээгээр хорогдсон байвал нөхөн сэргээх арга хэмжээг авна. Хэрэв ойт хээрийн бүсэд ойн зурваст суулгасан мод сөөгний амьдралд 50 хувиас доогуур, их хэмжээгээр үхэж үрэгдсэн байвал нөхөн тарилт хийхгүйгээр уг ажлыг эхнээс нь шинээр ахин явуулах нь зүйтэй.




Булган аймгийн хэмжээнд элсний нүүдлээс хамгаалах, ус, булгийн эхийг хамгаалах, тариалангийн талбайг хамгаалах, хатуу хучилттай авто зам дагуух 1376.8 км урт хамгаалалтын ойн зурвасуудыг байгуулахаар төлөвлөсөн бөгөөд ойн зурвасын туузын өргөнийг 10 метрээр тооцсон. /Хүснэгт 104/.

Хүснэгт 104. Хамгаалалтын ойн зурвасын төлөвлөгөө

№	Сумын нэр	Тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас		Зам дагуух хамгаалалтын ойн зурвас		Ус, булгийн эхийг хамгаалах ойн зурвас		Элсний нүүдлээс хамгаалах ойн зурвас		Нийт	
		Урт, км	Талбай, га	Урт, км	Талбай, га	Урт, км	Талбай, га	Урт, км	Талбай, га	Урт, км	Талбай, га
1	Баян-Агт	44.0	44.2							44.0	44.2
2	Баяннуур	15.7	15.8	38.2	38.3					53.9	54.1
3	Бугат	55.6	55.8	11.9	11.9					67.5	67.6
4	Булган									0.0	0.0
5	Бүрэгхангай	103.2	103.5							103.2	103.5
6	Гурванбулаг	53.3	53.6	23.2	23.2	3.1	3.2	6.5	6.7	86.1	86.6
7	Дашинчилэн	60.2	60.3	52.8	52.9					113.0	113.2
8	Могод	39.5	39.7	1.2	1.2					40.7	40.9
9	Орхон	90.2	90.8	50.4	50.5					140.7	141.3
10	Рашаант	93.3	93.6	10.5	10.6			9.8	10.0	113.6	114.1
11	Сайхан	77.9	78.1			11.8	11.9			89.7	90.1
12	Сэлэнгэ	127.0	127.4							127.0	127.4
13	Тэшиг	104.9	104.8							104.9	104.8
14	Хангал	51.3	51.0							51.3	51.0
15	Хишиг-Өндөр	49.8	50.0							49.8	50.0
16	Хутаг-Өндөр	179.7	180.5			3.3	3.5			183.0	183.9
НИЙТ		1145.8	1149.0	188.2	188.4	18.2	18.6	16.3	16.6	1368.5	1372.6

Ойн хамгаалалтын зурвасын талбайг тооцон гаргахдаа зурвасыг 10 метрийн өргөнтэй байхаар тооцон гаргасан. Тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвасыг тооцохдоо Монгол орны салхины зонхилох чиглэл болох хойд, баруун хойд чиглэлд талбайгаас 30 метрийн зайд 10 метр өргөнтэй байхаар тооцон гаргасан.

Ус, булгийн эхийг хамгаалах ойн зурвасыг орон нутгийн гаргасан саналыг харгалзан ус, булгийн татмыг гадуур 10 метр өргөнтэй байхаар салхины эсрэг чиглэлд байхаар тооцон гаргасан. Элсний нүүдлээс хамгаалах зурвасыг Гурванбулаг, Рашаант сумдад элсний заагийн дагуу төлөвлөн гаргасан.



Зураг 106. Ойн хамгаалалтын зурвасын газрын төлөвлөгөө

2.4.4. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН НӨХӨРЛӨЛ ГЭРЭЭГЭЭР АШИГЛУУЛАХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д “ойн нөхөрлөл” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх зорилгоор Иргэний хуулийн 481 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3-р зүйлийн 2 дахь хэсгийн 8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй иргэдийн сайн дурын байгууллагыг хэлнэ гэж заасан байдаг. Булган аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар 171 нөхөрлөл ойн зохион байгуулалт хийлгэн ойн хэсэглэлээ заалган үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд ойн менежментийн нөхөрлөлд гэрээгээр ашиглуулах ойн газрыг сонгохдоо орон нутгийн саналыг харгалзахаас гадна ойн ашиглалтын бүсийн нөхөрлөлийн ашиглалтад олгогдоогүй үйлдсэн газруудыг төлөвлөн оруулсан.


Булган аймгийн ашиглалтын бүсийн ой бүхий 5 суманд 61 ойн менежментийн нөхөрлөлд гэрээгээр ашиглуулах 207.8 мян.га газрыг төлөвлөсөн.

Хүснэгт 105. Ойн менежментийн нөхөрлөл гэрээгээр ашиглуулах газрын төлөвлөгөө

№	Сумын нэр	Нөхөрлөлд олгох ойн хэсэглэл	Талбай /га/
1	Бугат	176	879.3
2	Бугат	105, 126, 127, 128	2,492.0
3	Бугат	102, 124, 125	1,728.2
4	Бугат	147, 148, 149	3,288.3
5	Бугат	296, 297, 295, 294, 287	5,981.1
6	Бугат	88, 108, 110, 133, 134	4,396.9
7	Бугат	166, 167, 168, 169	4,253.5
8	Бугат	165, 197, 198	3,004.9
9	Бугат	94, 95, 118, 139	3,089.4
10	Бугат	58, 59, 78, 79	3,518.8
11	Бугат	23, 24, 40, 41	2,968.7
12	Бугат	25, 26, 42, 43, 60	4,229.4
13	Бугат	27, 28, 45	2,730.8
14	Бугат	44, 61, 62	2,714.9
15	Бугат	46, 47, 63, 64	3,257.7
16	Бугат	140, 142, 170	2,482.7
17	Бугат	185, 186, 213, 214, 215, 236	5,712.4
18	Бугат	152, 153, 154, 155, 156, 184	6,010.6
19	Бугат	212, 183, 182	3,226.3
20	Бугат	230, 231, 232, 233, 254	5,245.0
21	Бугат	150, 181, 179, 180, 211, 210	5,537.6
22	Сэлэнгэ	382	860.7
23	Сэлэнгэ	277	705.6
24	Тэшиг	457, 516, 562, 563	2,857.7
25	Тэшиг	564, 614, 615, 616	2,719.7
26	Тэшиг	560, 515, 561, 611	3,389.7
27	Тэшиг	609, 610, 612, 613, 661	5,536.3
28	Тэшиг	714, 715, 716, 662, 663, 750	5,458.7
29	Тэшиг	791, 792, 793	2,583.2
30	Тэшиг	717, 752, 751, 795, 794	4,791.1
31	Тэшиг	664, 617, 665, 666, 718	3,310.3
32	Тэшиг	567, 568, 569, 618, 619, 620	4,545.4
33	Тэшиг	666, 720, 719, 753	3,785.4
34	Тэшиг	796, 797, 754, 755	4,374.4
35	Тэшиг	570, 622, 623, 624, 621	4,319.6
36	Тэшиг	669, 722, 723, 670	4,467.7
37	Тэшиг	625, 626, 672, 671	2,780.8
38	Тэшиг	759, 760, 761, 801, 802,	2,999.8
39	Тэшиг	673, 674, 727, 724, 725, 726	3,362.5
40	Тэшиг	763, 762, 803, 802	3,455.5
41	Тэшиг	841, 843, 804, 805, 806, 764	3,436.4
42	Тэшиг	807, 765, 766, 767, 768, 809	3,798.8

**БУЛГАН АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

43	Тэшиг	721, 757, 756, 798, 799, 758	4,709.9
44	Хангал	7, 14	1,727.3
45	Хангал	2, 10, 23, 9, 20	4,665.8
46	Хангал	19, 30, 31	3,023.9
47	Хангал	28, 29, 36, 37	2,865.5
48	Хангал	38, 39, 53, 54	3,525.9
49	Хангал	128	751.3
50	Хангал	95	761.7
51	Хангал	159, 160, 161, 168	2,866.9
52	Хангал	120, 121	2,025.5
53	Хангал	84, 85, 87, 99, 112	3,953.6
54	Хангал	72, 73, 74, 59, 60, 75	4,274.1
55	Хутаг-Өндөр	124, 125, 126	3,796.5
56	Хутаг-Өндөр	197, 198	1,352.8
57	Хутаг-Өндөр	134, 167, 204, 203	4,178.1
58	Хутаг-Өндөр	163, 200, 201	2,443.1
59	Хутаг-Өндөр	164, 165, 166, 202	3,269.7
60	Хутаг-Өндөр	205, 206, 250	2,554.8
61	Хутаг-Өндөр	168, 169, 137, 138, 170	4,861.9
НИЙТ			207,895.9



Зураг 107. Ойн менежментийн нөхөрлөлд гэрээгээр ашиглуулах газрын төлөвлөгөө

2.4.5. ОЙЖУУЛАЛТ, ОЙН ТАРИМЛЫН ҮР, СУУЛГАЦ ҮРЖҮҮЛЭХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улсын хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор модны суулгац, үржүүлгийн аж ахуй нэн чухал ач холбогдолтой болоод байна. Ойжуулалт, мод тарих ажлыг үр дүнтэй явуулахын тулд Булган аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрт тусгагдсан 20 сая тарьц, суулгац шаардлагатай байна.

Шилмүүст модны тарьц, суулгац ургуулах талбай нь тухайн зүйлийн модны ой ургасан газар, уг ойн тархалтын хил зааг дотор байхаар, навчит мод, сөөгний тарьц, суулгац ургуулах талбай нь тухайн зүйлийн модны ой ургасан газарт, уг ойн тархалтын хил зааг дотор байхаар тооцон төлөвлөсөн. Аймгийн хэмжээнд 11 сумын 41 байршилд 61.7 газарт мод үржүүлгийн газар байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 106. Мод үржүүлгийн газрын төлөвлөгөө

№	Сумын нэр	Байршил	Талбай, га
1	Баян-Агт	5	11.0
2	Бугат	8	11.3
3	Гурванбулаг	1	2.0
4	Дашинчилэн	2	1.5
5	Могод	1	3.0
6	Орхон	4	5.9
7	Сайхан	3	4.0
8	Сэлэнгэ	11	15.9
9	Хангал	4	5.1
10	Хишиг-Өндөр	1	1.0
11	Хутаг-Өндөр	1	1.0
НИЙТ		41	61.7

Мод үржүүлгийн талбайн газрын гадарга тэгш байх ба 2-3 градусаас дээшгүй налуутай байна. Уулын дэвсэг хажуу газар бол 12 градус хүртэл налуутай байж болно. Талбай нь хүйтэн, халуун хуурай салхинаас хамгаалагдсан нөмөр газар байх ба эргэн тойрондоо хаалттай хонхор газар байж болохгүй. Цас, мөс борооны усны үерт автагдахааргүй газар сонгосон.


Мод үржүүлгийн газрын талбайг усалж болох байнга ундаргатай, тасарч ширгэдэггүй гол, горхи, цэнгэг нуур, цөөрмийн усыг ашиглахаар түшиглэн байгуулна. Усгүй нөхцөлд гүн өрмийн худаг түшиглэн байгуулна. Мөн усны давсны хэмжээ 0.1-0.5 хувиас ихгүй байна.

Хүснэгт 107. Мод үржүүлгийн газрын төлөвлөгөө

№	Сумын нэр	Газрын нэр	Уртраг	Өргөрөг	Талбай, га
1	Баян-Агт	Дал	102°33'55.0"	48°56'02.2"	5
2	Баян-Агт	Цийлэн	101°38'17.1"	49°04'51.7"	3
3	Баян-Агт	Их булаг	101°58'26.9"	49°06'12.4"	1
4	Баян-Агт	Хойд салаа	102°06'05.6"	49°02'59.0"	1
5	Баян-Агт	Урд салаа	102°06'44.5"	49°02'24.2"	1
6	Бугат	Их зоо	103°36'33.7"	48°53'06.7"	1
7	Бугат	Зоон давааны жалга	103°37'30.6"	48°54'02.3"	1
8	Бугат	Зуун мод	103°20'49.9"	48°54'31.0"	0.3
9	Бугат	Зүүн Түрүүний эх	103°28'16.0"	48°59'40.6"	1
10	Бугат	Бага нарс, их нарстын дунд	103°37'52.5"	49°01'23.6"	1
11	Бугат	Аргалтын үзүүр	103°51'0.9"	49°04'21.4"	1
12	Бугат	Өргөө булагт	103°53'19.1"	49°04'58.9"	5
13	Бугат	Дархитын эх	103°42'56.4"	49°01'05.0"	1
14	Гурванбулаг	Сумын төв	103°29'55.9"	47°44'27.3"	2
15	Дашинчилэн	Үржил	104°02'10.2"	47°50'03.1"	1
16	Дашинчилэн	Сумын төв /Төв зам дагуу/	104°03'24.0"	47°51'53.2"	0.5
17	Могод	Хуурайн ам	102°55'26.6"	48°17'32.5"	3
18	Орхон	Орхон хангал голын бэлчир	103°26'47.5"	48°47'38.5"	1
19	Орхон	Байшинт	104°35'46.2"	48°50'47.7"	0.89

**БУЛГАН АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

20	Орхон	Залуугийн булаг	103°56'31.1"	48°57'07.4"	2
21	Орхон	Хөх чулууны ар	104°03'47.0"	48°56'30.6"	2
22	Сайхан	Тахилт	102°11'50.5"	48°46'04.5"	2
23	Сайхан	Хөндлөн бүрд	102°50'43.3"	48°51'51.5"	1
24	Сайхан	Бадамын даваа	102°33'42.2"	48°54'49.8"	1
25	Сэлэнгэ	Сумын төв /Моностой/	104°00'00.1"	49°27'09.1"	1
26	Сэлэнгэ	Хайлантай	104°17'10.3"	49°35'46.2"	0.1
27	Сэлэнгэ	Хайлантайн голын адаг	104°18'21.4"	49°33'58.1"	0.5
28	Сэлэнгэ	Хайлантайн голын адаг	104°18'32.7"	49°33'44.4"	1.6
29	Сэлэнгэ	Хайлантайн голын адаг	104°18'32.7"	49°33'31.8"	1.1
30	Сэлэнгэ	Хялганат нуга	104°18'33.2"	49°32'48.7"	2
31	Сэлэнгэ	Хялганат нуга	104°18'40.7"	49°32'51.8"	2
32	Сэлэнгэ	Хялганат тосгон	104°17'57.3"	49°28'47.8"	0.17
33	Сэлэнгэ	Дүгэрээ нуга	104°15'30.8"	49°27'60.0"	1.7
34	Сэлэнгэ	Шаварын гол	104°08'36.0"	49°28'42.3"	5
35	Сэлэнгэ	Шаварын гол	104°08'32.0"	49°29'27.9"	0.7
36	Хангал	Цулхар	104°19'39.0"	49°27'55.7"	1.1
37	Хангал	Сайрын хөтөл	104°22'49.8"	49°26'42.9"	2
38	Хангал	Сумын төв	104°23'18.8"	49°18'29.9"	1
39	Хангал	Чулуут	104°11'44.5"	49°13'49.8"	1
40	Хишиг-Өндөр	Хонхор нуур	103°49'07.4"	47°54'04.5"	1
41	Хутаг-Өндөр	Сумын төвийн зүүн урд	102°42'09.2"	49°22'53.4"	1
НИЙТ					61.7



Зураг 108. Мод үржүүлгийн газрын төлөвлөгөө

2.4.6. ОЙН ТЭЛЭН УРГАХ НӨӨЦ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


Ойн тухай хуулийн 3.1.2-т заалтад зааснаар ойн сан гэж ой, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ой тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг хэлнэ гэж заасан байдаг. Мөн кадастрын зураглалын ажлын барилгын норм ба дүрэмд зааснаар ой тэлэн ургах нөөц газрын ойн цахаас гадагш 100 метр байхаар тооцон зураглана гэж заасны дагуу Булган аймгийн ой тэлэн ургах нөөц газрын тооцон гаргасан.

Аймгийн хэмжээнд ойн сан бүхий газрын 16.3 хувь буюу 313.6 мян.га ой тэлэн ургах газрыг төлөвлөсөн.

Хүснэгт 108. Ойн тэлэн ургах нөөц газрын төлөвлөгөө

№	Сумын нэр	Ойн сан бүхий газар, га	Ой тэлэн ургах нөөц газар, га	Нийт ойн санд эзлэх, %
1	Баян-Агт	77,806.5	36,255.4	46.6
2	Баяннуур	783.8	1,134.4	144.7
3	Бугат	191,960.4	43,239.1	22.5
4	Булган	594.0	240.8	40.5
5	Бүрэгхангай	25,451.8	4,187.2	16.5
6	Гурванбулаг	2,816.9	2,145.0	76.1
7	Дашинчилэн	112.5	221.8	197.2
8	Могод	30,014.7	4,807.2	16
9	Орхон	78,384.4	40,203.5	51.3
10	Рашаант	3,844.1	1,088.1	28.3
11	Сайхан	14,665.2	8,439.8	57.6
12	Сэлэнгэ	399,167.9	26,081.8	6.5
13	Тэшиг	649,766.3	44,946.1	6.9
14	Хангал	110,199.3	21,723.5	19.7
15	Хишиг-Өндөр	33,643.0	8,861.3	26.3
16	Хутаг-Өндөр	304,699.4	70,022.0	23
НИЙТ		1,923,910.2	313,597.0	16.3

Ой тэлэн ургах нөөц газрын сумдаар авч үзвэл ойн сангийн талбайн хэмжээнээс хамаараад янз бүр байна. Ойгоор бүрхэгдсэн газар ихтэй Сэлэнгэ, Хангал, Бугат, Тэшиг, Хутаг-Өндөр, Орхон сумдын ой тэлэн ургах газар их байна. Мөн ой сангийн талбай Баяннуур, Дашинчилэн сумдын ой тэлэн ургах нөөц газар нь ой модоор бүрхэгдсэн газраасаа их байна.



Зураг 109. Ойн сан бүхий газрын төлөвлөгөө

2.4.7. ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ

Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ойн сан бүхий газрын төлөвлөгдсөн арга хэмжээг үе шатанд хуваан тусгасан. Ингэхдээ тусгагдсан арга хэмжээний цар хүрээ, орон нутгийн санал, бусад бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хугацаа зэргийг харгалзан тусгасан.

Булган аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ойрын буюу 2022-2025 онуудад 8.9 мян.га ойн хөнөөлт шавж, хортонтой тэмцэх, 11.6 мян.га талбайд ойжуулалт хийж, 5.1 мян.га ойн байгалийн сэргэн ургалтад туслан сайжруулж, 1.5 мян.га талбайд мод тарьж, 0.6 мян.га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулахаар, ойн менежментийн нөхөрлөлд гэрээгээр ашиглуулах 152.5 га газар, 8.2 мян.га талбайгаар цэвэрлэгээний мод огтлохоор тус тус төлөвлөсөн. Мөн 29 байршилд мод үржүүлгийн газар байгуулах төлөвлөсөн.

Төлөвлөлтийн дунд буюу 2026-2029 онуудад аймгийн хэмжээнд 103.0 мян.га, урт буюу 2030-2034 онуудад 27.2 мян.га талбайд ойн хөнөөлт шавж, хортон тэмцэх, цэвэрлэгээний мод отгох, ойн менежментийн нөхөрлөлд гэрээгээр ашиглуулах, хамгаалалтын ойн зуравс байгуулах, мод тарих, байгалийн сэргэн ургалтад туслан сайжруулах, ойжуулах зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөсөн /Хүснэгт 109/.

Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс үзэхэд нийт 3 байршлыг шинээр улсын тусгай хамгаалалтад авах болон тусгай хамгаалалттай газрын заагийг өргөтгөхөөр тусгасан бол хээрийн судалгааны явцад орон нутгаас 3 байршлыг шинээр улсын тусгай хамгаалалтад авах санал гаргасан. Мөн Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр суманд байрлах “Зэд-хантай” дархан цаазат газрыг хэсэгчлэн зэрэглэл бууруулах саналыг гаргасан.

Хүснэгт 124. Улсын тусгай хамгаалалтад авах газар

№	Газрын нэр	Тусгай хамгаалалттай газрын ангилал	Харьяалагдах сум	Талбайн хэмжээ /га/
Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө				
1	Бүрэнгийн нуруу	Байгалийн нөөцийн газар	Хангал	16,751.8
2	Дулаан хаан уул	Байгалийн нөөцийн газар	Тэшиг	15,516.5
3	Уран тогоо байгалийн дурсгалт газрын өргөтгөл	Дурсгалт газар	Хутаг-Өндөр сум	3,802.2
НИЙТ				168,631.5
Орон нутгийн санал				
1	Цагаан нуур	Байгалийн нөөцийн газар	Баяннуур, Дашинчилэн	1,447.7
2	Чин толгой	Дурсгалт газар	Дашинчилэн	2,398.1
3	Хөл асгат	Дурсгалт газар	Могод	2,909.8
4	Зэд хантай бүтээлийн нуруу	Дархан цаазат газар	Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ	545,477.7
НИЙТ				56,395.4


Бүрэнгийн нуруу: Хангал сумын нутагт орших “Бүрэнгийн нуруу” орчимд 16.7 мян.га газрыг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн. Уг төлөвлөөд байгаа улсын тусгай хэрэгцээний газар Хангал сумын ИТХ-ын тогтоолоор Бүрэнгийн нуруу орчмын байгалийн нөөцийг хамгаалах зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газартай давхцаж байгаа тул давхцаж байгаа газрыг орон нутгийн тусгай хамгаалалтаас гаргаж ангилал дээшлүүлж улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөв.



Зураг 112. Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж буй газар “Бүрэнгийн нуруу”

Хамгаалалтад авах үндэслэл: Булган аймаг нь Монгол орны голын урсац бүрдэх ой модны нөөц, байгалийн зохицолдоог хангах, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалж үлдэхэд ач холбогдолтой аймаг юм. Булган аймгийн хилийг дамнан оршдог Бүрэнгийн нуруу орчим нь газрын Хүдэр, Буга, Зэрлэг гахай зэрэг амьтны амьдрах орчны сайжруулах, усны урсцын эх бүрдэх газрыг хамгаалахад чухал ач холбогдолтой бүс нутаг тул улсын тусгай хамгаалалтад байгалийн нөөцийн газрын ангилалд авахаар төлөвлөв.

Дулаанхаан уул: Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд “Дулаанхаан уул” орчмын Хөвсгөл аймгийн Тариалан, Булган аймгийн Тэшиг сумыг дамнасан 46.3 мян.га газрыг тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн боловч орон нутгийн санал, өнөөгийн байдлаар айл ихээхэн суурьшсан хэсгийг хасаж Тэшиг сумын 15.5 мян.га газрыг Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байгалийн цогцолборт газраар улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн.



Зураг 113. Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж буй газар “Дулаанхаан уул”


Хамгаалалтад авах үндэслэл: Дулаанхаан уулын орчим нь Эг, Сэлэнгэ голын ус зүйн сүлжээ бүрдүүлэхэд онцгой үүрэгтэй, Орхон-Сэлэнгийн савын дундаж уулсыг төлөөлөх энэ нутаг нь байгалийн унаган төрхөө сайн хадгалсан, аялал жуулчлал хөгжүүлэх өргөн боломж бүхий байгалийн өвөрмөц тогтоцтой нутаг байна.

Экологийн чухал ач холбогдолтой, хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай голуудын нам татам дагуух намгархаг нуга, уулсын ар хажуугаар тохиолдох тайгархаг шинэсэн, хусан ой, дундаж, нам уулсаар тохиолдох уулын хээр хослон гол мөрний өргөн хөндий, татмын нуга, цэнгэг уст гол, горхиуд, уулын хээр, ой мод хосолсон үзэсгэлэнт, байгалийн унаган төрхөөрөө байгаа газар юм. Тэшиг сумын орчмын бүс нутагт амьтны тухай хуульд сүүн тэжээлтэн, шувуу тус бүрээс нэг зүйл нэн ховор амьтнаар орсон байна. Эг, Сэлэнгийн бэлчир, түүний орчмын бүс нутагт амьдарч буй 11 зүйлийн сүүн тэжээлтэн, 47 зүйлийн шувуу, 3 зүйл хоёр нутагтан, мөлхөгчид, 5 зүйл загас, нийт 66 зүйлийн сээр нуруутан амьтан аль нэг хэлбэрийн эрх зүйл хамгаалалтад орсон нь тухайн нутгийн амьтны аймгийн удмын сангийн үнэт чанарыг илэрхийлэх нэг үндсэн үзүүлэлт юм.

Байгаль орчинд үзүүлэх хүний сөрөг нөлөө ихэссээр байгаа өнөө үед ард түмний байгалиа хамгаалж ирсэн уламжлалт зан үйлд тулгуурлан хушин ойн нөөцийг авч үлдэх, Хойт Мөсөн далайн ай савд хамаарах голуудын эх, цутгал голууд, Орхон-Сэлэнгийн савын дундаж уулсын ойт хээрийн экосистемийг хамгаалахад чухал ач холбогдолтой тул улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай.

“Уран тогоо” байгалийн дурсгалт газрын өргөтгөл: Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт байгалийн дурсгалт газрыг хамгаалах “Уран тогоо” уулын улсын тусгай хамгаалалтай газрыг өргөтгөж улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн юм.

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд “Уран тогоо” уулын өргөтгөж тусгай хамгаалалтад авах газрыг 16.0 мян.га байхаар төлөвлөсөн боловч орон нутгийн саналыг харгалзан одоогийн газар байдлаар айл суурьшсан, ямар нэгэн газар ашиглалт явагдсан газрыг хассан 3802.2 га байхаар тооцон төлөвлөгөөнд тусгасан.




Зураг 114. Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж буй газар “Уран тогоо уул”

Хамгаалалтад авах үндэслэл: Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт Уран, Тулга, Тогоо, Жалавч гэдэг дөрвөн унтарсан галт уулс оршдог. Дөрөвдөгч галавын үед оргилж байсан уулс бөгөөд хамгийн сүүлд 20-25 мянган жилийн тэртээ унтарчээ. Уран тогоо уул далайн төвшнөөс дээш 1686 метр өндөр, өрхний амсар нь сэтрээгүй бүтэн, 500-600 метр өргөн голчтой, гүн нь 50-60 метр бүхий өвөрмөц тогтоц бүхий байгалийн дурсгалт газар юм. Мөн Уран тогоо уулын орчим нь үржил шимт хар хүрэн ба хар шороон хөрстэй учир хээрийн ба ойт хээр, уулт хээрийн бүсийн ургамал ургадаг. Шинэсэн ой голлохоос гадна улиас, улиангар, хус ургана. Цагаан төмс, мангир, хонгорзул, алтанзул, алтангагнуур, тайжийн жинс, далан түрүү, үхэр гоньд, хунчир, хөвөн оройт, Монгол туйплан зэрэг эмийн болон хүнсний ургамал, хавтуул, хурган засаа, үнэгэн сүүл, хонхон цэцэг, бэр цэцэг, хазаар өвс зэрэг ургамал ургана.

Буга, аргаль, бор гөрөөс, гахай, янгир, тарвага, зурам, бор туулай, хөвдний бор оготно зэрэг ам амьтад бий. Ятуу, бор шувуу, ууль, харцага, хөхөө, өвөөлж байдаг ба Уран тогооны нууранд ангир ирж зусдаг. Энэ бүс нутагт хэвлээр явагч могой элбэг тохионо. Хүйтэн улиралд эдгээр галт уулын гүний дулаан бүлээн уур хийн илчинд хоргодон ичиж амьдардаг байна. Их тогоо уулын хавь нутагт булш, хиргисүүр нилээд бий. Иймд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд “Уран тогоо уул”-ын дурсгалт газрыг баруун тийш нь өргөтгөн хамгаалалтад авахаар төлөвлөсөн.

“Цагаан нуур” байгалийн нөөц газар: Булган аймгийн Дашинчилэн, Баяннуур сумын заагт орших Цагаан нуур орчмын ус намгархаг газар олон төрлийн нүүдлийн болон усны шувуудын ирж нутагладаг, үр төлөө үлдээдэг олон улсын ач холбогдолтой ус, намгархаг газар тул орон нутгаас гаргасан саналын дагуу байгалийн нөөцийг хамгаалах зорилгоор 1447.7 га газрыг улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн.


Уг төлөвлөөд байгаа улсын тусгай хэрэгцээний газар Дашинчилэн сумын ИТХ-ын тогтоолоор 2019 онд байгалийн экологийн тэнцвэр хадгалах зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газартай давхцаж байгаа тул давхцаж байгаа газрыг орон нутгийн тусгай хамгаалалтаас гаргаж ангилал дээшлүүлж төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөв.



Зураг 115. Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж буй газар “Цагаан нуур”

“Чин толгой” дурсгалт газар: Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших “Чин толгой” орчмын эртний хотын туурын түүх соёлын дурсгалын хамгаалах зорилгоор 2398.1 га газрын орон нутгийн саналыг дагуу улсын тусгай хамгаалалт авахаар төлөвлөсөн. Чин толгой орчмын эртний хотын туурь газарт эртний судлалын нарийн малтлага судалгаа хийгээгүй боловч судлаачид түүхийн сурвалж бичгийн мэдээнд тулгуурлан Киданы Чжэнь-Чжоу хотын үлдэгдэл гэж үзжээ.


Уг төлөвлөөд байгаа улсын тусгай хэрэгцээний газар Дашинчилэн сумын ИТХ-ын тогтоолоор 2019 онд байгалийн экологийн тэнцвэр хадгалах зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газартай давхцаж байгаа тул давхцаж байгаа газрыг орон нутгийн тусгай хамгаалалтаас гаргаж ангилал дээшлүүлж төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөв.



Зураг 116. Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж буй газар “Чин толгой”


“Хөл асгат” дурсгалт газар: Булган аймгийн Могод сумын нутагт орших “Хөл асгат” орчмын түүх соёлын дурсгалт хамгаалах зорилгоор 2909.8 га газрын орон нутгийн саналыг дагуу улсын тусгай хамгаалалт авахаар төлөвлөсөн.

Хөл асгат орчмын эртний түүх соёлын дурсгал нь газарт гурван хүний дүрстэй хавтан чулуу, ханан болон эвэр хээтэй хашлага чулуу, түрэг бичээстэй чулуу бүхий тахилын онгон бий. Зарим ном бүтээлд энэ дурсгалыг “Алтан тамган дархны дурсгал” хэмээн тэмдэглэсэн нь бий.



Зураг 117. Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж буй газар “Хөл асгат”

“Зэд хантай бүтээлийн нуруу” дархан цаазат газар: Булган аймгийн Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумын нийт 603.7 мян.га газрыг хамрах бөгөөд Хутаг-Өндөр сумын нутагт 49.2 мян.га газар, Сэлэнгэ суманд 239.2 мян.га, Тэшиг суманд 315.3 мян.га газрыг улсын тусгай хамгаалалтад авсан байна. Зэд-Хантай-Бүтээлийн нуруу нь сум, багийн төвөөс алслагдмал, улсын хил дагуу орших дундаж уулын тайга, намаг бүхий бартаа ихтэй нутаг бөгөөд газрын ашиглалт бараг хийгдээгүй онгон дагшин газар юм. Уг газрыг нэн ховор болон ховор, ховордож байгаа амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан байна.




Зураг 118. Улсын тусгай хамгаалалтад зэрэглэл бууруулахаар төлөвлөж буй газар “Зэд хантай бүтээлийн нуруу”

Зэд-хантай-Бүтээлийн нуруу орчмын байгаль орчны тэнцлийг хангах, унаган төрхийг хадгалан, хамгаалах зорилгоор УИХ-ын 2011 оны 18 дугаар тогтоолоор 603.7 мян.га газрыг дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан.

Хамгаалалтаас гаргах үндэслэл: Уг дархан цаазат газар нь Сэлэнгэ сумын нийт газар нутгийн 49.3 хувь, Тэшиг сумын газар нутгийн 40.7 хувь, Хутаг-Өндөр сумын газар нутгийн 8.7 хувийг тус тус эзэлж байна. Хутаг-Өндөр, Тэшиг сумдын хувьд уг дархан цаазат газар нь алслагдсан бүс нутаг боловч Сэлэнгэ сумын хувьд дархан цаазат газрын урд хэсгээр гол ашиглалттай давхцаж байна. Сэлэнгэ сум мал аж ахуй, газар тариалан хосолсон сум боловч ойн сан бүхий газрын талбай болон газар тариалангийн талбайгаас шалтгаалан бэлчээрийн талбай тун ховор юм.

Иймд хээрийн судалгаагаар орон нутгийн иргэдийн “Зэд-Хантай-Бүтээлийн нуруу” дархан цаазат газрын Сэлэнгэ суманд хамаарагдах нутгийн урд хэсгээс 59400.1 га газрыг хасах саналыг үндэслэн дархан цаазат газрыг 545.4 мян.га болгож хил заагийг шинэчлэв.

“Зэд-Хантай-Бүтээлийн нуруу” дархан цаазат газрын 545.4 мян.га газрыг хэвээр үлдээж 59.4 мян.га газрыг хасахаар төлөвлөв.



Зураг 119. Улсын тусгай хамгаалалтад авах газрын төлөвлөгөө

2.6.2. ШИНЭЭР ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар гэдэг нь “Тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад авсан газрыг хэлнэ.” гэж газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай журамд заасан байдаг.

Уг төлөвлөгөөнд орон нутгийн саналыг үндэслэн орон нутгийн тусгай хамгаалалтад сумын тусгай хэрэгцээнд 13 сумын 90 байршилд 717.9 мян.га орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар төлөвлөв.

Орон нутгийн тусгай хамгаалалтад шинээр авах газрыг төлөвлөхдөө газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ойрын буюу 2022-2025 онуудад орон нутгийн тусгай хэрэгцээнд авч зохих журмын дагуу мэдээллийн санд бүртгүүлэхээр тооцсон.


Хүснэгт 125. Орон нутгийн тусгай хамгаалалтад авах газрын төлөвлөгөө

№	Сумын нэр	Газрын нэр	ТХ-д авах үндэслэл	Газрын хэмжээ, га
1	Баян-Агт	Цэгээн нуур	Байгалын унаган төрхийг хадгалах	3,339.9
2	Баян-Агт	Хөвсгөлийн нуруу	Байгалын унаган төрхийг хадгалах	27,729.7
3	Баян-Агт	Агьтийн нуруу	Байгалын унаган төрхийг хадгалах	11,542.5
4	Баян-Агт	Сүүж, Дарстын нуруу	Байгалын унаган төрхийг хадгалах	18,901.1
5	Баян-Агт	Цагаан агт уул	Байгалын унаган төрхийг хадгалах	3,330.0
6	Баян-Агт	Бор нуруу	Байгалын унаган төрхийг хадгалах	28,425.2
7	Баян-Агт	Шарга нуур	Байгалын унаган төрхийг хадгалах	3,773.4
8	Баян-Агт	Хануй гол	Байгалын унаган төрхийг хадгалах	1,159.6
9	Баян-Агт	Шивээт улаан	Байгалын унаган төрхийг хадгалах	2,486.5
10	Баян-Агт	Хөвсгөлийн нуруу	Байгалын унаган төрхийг хадгалах	796.6
11	Баяннуур	Молцог элс	Байгалийн нөөцийг хамгаалах	22,504.0

**БУЛГАН АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

12	Баяннуур	Их, Бага Агьт	Байгалийн үзэсгэлэнт газрын хамгаалах	1,502.8
13	Баяннуур	Бор тал	Байгалийн нөөцийг хамгаалах	5,790.1
14	Баяннуур	Зааны хөндий	Байгалийн нөөцийг хамгаалах	29,726.1
15	Баяннуур	Баян Улаан	Түүх, соёлын дурсгалын хамгаалах	9,149.9
16	Баяннуур	Далын гол	Байгалийн нөөцийг хамгаалах	18,080.8
17	Бүрэгхангай	Баянтөгс уул	Байгалын унаган төрхийг хадгалах	8,123.9
18	Бүрэгхангай	Алтанга уул	Байгалын унаган төрхийг хадгалах	10,015.1
19	Бүрэгхангай	Бичигт хад, байтаг	Түүх, соёлын дурсгалын хамгаалах	4,172.1
20	Бүрэгхангай	Гээг нуга	Түүх соёлын дурсгалын хамгаалах	3,929.1
21	Бүрэгхангай	Бүрэгийн нуруу	Байгалын унаган төрхийг хадгалах	16,765.6
22	Бүрэгхангай	Шар хадны нуруу	Байгалын унаган төрхийг хадгалах	7,574.1
23	Бүрэгхангай	Хавирга Гуай уул	Байгалын унаган төрхийг хадгалах	779.7
24	Бүрэгхангай	Арцат	Байгалын унаган төрхийг хадгалах	1,915.1
25	Бүрэгхангай	Баянхангай	Байгалын унаган төрхийг хадгалах	2,883.5
26	Бүрэгхангай	Түлүүжингийн эх	Байгалын унаган төрхийг хадгалах	1,249.4
27	Бүрэгхангай	Их Загзаг уул	Байгалын унаган төрхийг хадгалах	11,544.3
28	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	18.3
29	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	135.6
30	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	37.0
31	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	5.6
32	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	4.8
33	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	3.0
34	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	6.2
35	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	40.6
36	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	31.1
37	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	222.7
38	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	476.8
39	Бүрэгхангай	Туул гол дагуух эвдэрсэн газар	Эвдэрсэн газрыг хамгаалалтад авах	10.1
40	Бүрэгхангай	Туул гол дагуу	Байгалийн унаган төрхийг хадгалах	54.1
41	Бүрэгхангай	Туул гол дагуу	Байгалийн унаган төрхийг хадгалах	450.3
42	Бүрэгхангай	Туул гол дагуу	Байгалийн унаган төрхийг хадгалах	477.7
43	Бүрэгхангай	Цахт баг	Байгалийн унаган төрхийг хадгалах	72,432.2
44	Бүрэгхангай	Их Дулаан уул, Ум уул, Эмгэнт, Өвгөнт	Байгалийн унаган төрхийг хадгалах	42,595.2
45	Бүрэгхангай	Дэрст баг	Байгалийн унаган төрхийг хадгалах	68,676.1
46	Бүрэгхангай	Бумбат баг	Байгалийн унаган төрхийг хадгалах	47,736.0
47	Гурванбулаг	Баяндүүрэх	Байгалийн унаган төрхийг хадгалах	12,484.6
48	Дашинчилэн	Туул гол дагуу	Байгалийн нөөцийг хамгаалах	163.5
49	Дашинчилэн	Агитын хөндий, Хөтөл ухаа, Толгойт уул	Байгалийн нөөцийг хамгаалах	4,864.8
50	Дашинчилэн	Мөсөнгийн хүрэн ухаа	Байгалийн нөөцийг хамгаалах	613.0
51	Могод	Улаан хаалга - Бураат	Байгалийн өвөрмөц тогтоц болон соёлын дурсгал хамгаалах	4,884.3
52	Могод	Цахиурт толгой	Түүх, соёлын өвийг хамгаалах	825.2
53	Могод	Хульжийн рашаан	Байгалийн унаган төрхийг хадгалах	353.2
54	Орхон	Уушиг уул	Байгалийн унаган төрхийг хадгалах	819.9
55	Орхон	Нарийн хөндий, Чингэл Орхон	Байгалийн унаган төрхийг хадгалах	11,135.7
56	Орхон	Өрөм ар булаг	Байгалийн унаган төрхийг хадгалах	14,618.5
57	Орхон	Улаан хадат уул	Байгалийн унаган төрхийг хадгалах	2,920.2
58	Орхон	Халиун уул	Байгалийн унаган төрхийг хадгалах	5,033.6
59	Орхон	Их Мээж	Байгалийн унаган төрхийг хадгалах	4,333.7
60	Орхон	Бага Мээж	Байгалийн унаган төрхийг хадгалах	1,891.3
61	Рашаант	Их Аргал Уул	Байгалийн нөөц газрын хамгаалах	7,778.7
62	Рашаант	Хуягтын сайр	Гүний усны тэжээгдлийн мужийг хамгаалах	1,083.4
63	Сайхан	Сайхан уул	Тахилгат газрын хамгаалах	1,410.3
64	Сайхан	Хунт рашаант	Байгалийн үзэсгэлэнт газрын хамгаалах	2,555.1
65	Сайхан	Атайт	Байгалийн нөөц газрын хамгаалах	7,353.6
66	Сайхан	Цөнгөрөг	Байгалийн нөөц газрын хамгаалах	2,368.2
67	Сайхан	Ундрах уул	Байгалийн нөөц газрын хамгаалах	1,069.0
68	Сайхан	Өргөөт, хиргисийн хөндий ОНТХ	Байгалийн нөөц газрын хамгаалах	2,530.2
69	Сайхан	Нарийн хүрэмт	Байгалийн нөөц газрын хамгаалах	961.2
70	Сайхан	Бага хайрхан	Байгалийн нөөц газрын хамгаалах	1,552.9

71	Сайхан	Асгийн дэвсэг	Байгалийн нөөц газрын хамгаалах	272.2
72	Сайхан	Өрхтэй	Байгалийн нөөц газрын хамгаалах	4,301.9
73	Сайхан	Орхон голын сав газар	Байгалийн үзэсгэлэнт газрын хамгаалах	6,202.7
74	Сайхан	Мээрэнт	Байгалийн нөөц газрын хамгаалах	7,318.9
75	Тэшиг	Хавчуугийн гол, Сант толгой	Байгалийн нөөц газрын хамгаалах	4,391.1
76	Тэшиг	Эмт	Байгалийн нөөц газрын хамгаалах	11,220.6
77	Хангал	Асгатын гол, Сангийн гол	Байгалийн унаган төрхийг хадгалах	6,327.1
78	Хангал	Хандгайт, Хавчуу	Байгалийн нөөц газрын хамгаалах	19,444.8
79	Хангал	Асгатын гол, Сангийн гол	Байгалийн унаган төрхийг хадгалах	3,783.4
80	Хишиг-Өндөр	Орхон гол, Булангийн хөндий	Байгалийн нөөц газрын хамгаалах	4,572.3
81	Хишиг-Өндөр	Хишиг-Өндөр уул	Байгалийн нөөц газрын хамгаалах	10,398.4
82	Хишиг-Өндөр	Хөшөөт-Жагайт голын билчир	Байгалийн нөөц газрын хамгаалах	1,828.3
83	Хишиг-Өндөр	Суварга, Дөш, Жаргалант уул	Байгалийн нөөц газрын хамгаалах	11,322.3
84	Хишиг-Өндөр	Нарт толгод, Хонхор нуур, Баян ар	Байгалийн нөөц газрын хамгаалах	18,050.2
85	Хишиг-Өндөр	Өл	Байгалийн нөөц газрын хамгаалах	4,115.3
86	Хишиг-Өндөр	Мөнгөн уул	Байгалийн унаган төрхийг хадгалах	3,906.4
87	Хишиг-Өндөр	Жаргалант уул	Байгалийн унаган төрхийг хадгалах	3,173.3
88	Хишиг-Өндөр	Дархан Хаан уул	Байгалийн унаган төрхийг хадгалах	2,426.9
89	Хишиг-Өндөр	Баян Хангай уул	Байгалийн унаган төрхийг хадгалах	1,084.4
90	Хутаг-Өндөр	Мухар хөндий, Тахилтын эх авах санал	Байгалийн унаган төрхийг хадгалах	9,582.0
НИЙТ				717,930.1




Зураг 120. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөө

2.6.3. УУЛ УУРХАЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА ДУУСАХААР ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын эдийг засаг, нийгмийн хөгжилд уул уурхайн салбар чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч уг салбар нь уламжлалт мал ахуйн салбарт ихээхэн сөрөг нөлөө дагуулсан ирсэн билээ. Иймд Булган аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр уул уурхайн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаар орон нутгийн тусгай хамгаалалтад авч хамгаалахаар төлөвлөсөн.

Булган аймгийн хэмжээнд ашиглалтын болон хайгуулын 107 тусгай зөвшөөрөлд 90706.4 га газар олгогдсон ба энэ нь нийт газар нутгийн 1.9 хувь байна. Эдгээр уул уурхайн

тусгай зөвшөөрөлтэй талбайнаас 55 тусгай зөвшөөрлийн хугацаа төлөвлөлтийн хугацаанд дуусахаар байгаа тул орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн.




Диаграмм 9. Орон нутгийн тусгай хамгаалалтад авах уул, уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай

Аймгийн хэмжээнд 11 сумын 55 тусгай зөвшөөрөлтэй 54085.9 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөсөн ба үүнийг 63.9 хувь буюу 34593.76 га талбайн Бүрэгхангай суманд байна.

Хүснэгт 126. Орон нутгийн тусгай хамгаалалтад авах уул, уурхайн тусгай зөвшөөрөлтэй газрын төлөвлөгөө

№	Сумын	Лицензийн дугаар	Нэр	Төрөл	Дуусах хугацаа	Газрын хэмжээ, га
1	Баяннуур	XV-63000024 (63000024)	Цагаан толгойн боржин	Хайгуул	5/31/2022	30.1
2	Баяннуур	XV-021852	Баяннуур	Хайгуул	7/21/2024	1854.5
3	Бугат	XV-63000025 (X-0014)	Хүрэн булгийн овоо	Хайгуул	12/4/2021	30.1
4	Бүрэгхангай	XV-014947	Чулуут	Хайгуул	6/23/2021	91.4
5	Бүрэгхангай	XV-019797	Борог	Хайгуул	6/13/2022	3049.9
6	Бүрэгхангай	XV-020470	Туул	Хайгуул	2/23/2022	18906.0
7	Бүрэгхангай	XV-019809	Тээл	Хайгуул	7/19/2022	853.9
8	Бүрэгхангай	XV-019129	Бүрэгхангай-1	Хайгуул	4/6/2022	60.6
9	Бүрэгхангай	XV-019210	Өндөр эрэг	Хайгуул	8/11/2022	262.6
10	Бүрэгхангай	XV-019254	Бүрэг	Хайгуул	5/3/2022	1000.2
11	Бүрэгхангай	XV-021217	Тосон	Хайгуул	1/29/2022	173.3
12	Бүрэгхангай	XV-019129	Бүрэгхангай-1	Хайгуул	4/6/2022	160.6
13	Бүрэгхангай	XV-019564	Шар ус	Хайгуул	7/5/2022	300.8
14	Бүрэгхангай	XV-019927	Өндөр уул	Хайгуул	1/15/2022	110.6
15	Бүрэгхангай	XV-021337	Өндөр дэнж	Хайгуул	6/20/2022	1573.6
16	Бүрэгхангай	XV-021349	Баруун дэнж	Хайгуул	7/1/2022	133.2
17	Бүрэгхангай	XV-021351	Дэлэн	Хайгуул	6/24/2022	515.9
18	Бүрэгхангай	XV-017614	Хадан	Хайгуул	5/31/2024	411.9
19	Бүрэгхангай	XV-021763	Тамсаг-2	Хайгуул	4/5/2024	467.7
20	Бүрэгхангай	XV-019231	Од	Хайгуул	1/4/2022	1533.6
21	Бүрэгхангай	XV-63000006	Ум уул	Хайгуул	3/7/2022	386.7
22	Бүрэгхангай	MV-019852	Ар тамсаг-1-2	Ашиглалт	12/8/2034	303.7
23	Бүрэгхангай	MV-009623	Ар тамсаг-1-2-2	Ашиглалт	12/8/2034	418.0
24	Бүрэгхангай	MV-015424	Ар тамсаг	Ашиглалт	12/8/2034	71.1
25	Бүрэгхангай	MV-020955	Ар тамсаг-1-1-2	Ашиглалт	7/26/2034	119.1
26	Бүрэгхангай	MV-008863	Ар тамсаг-1-1	Ашиглалт	12/8/2034	664.1
27	Бүрэгхангай	MV-011881	Ар тамсаг-1-1-1	Ашиглалт	12/8/2034	176.8
28	Бүрэгхангай	MV-000321	Тосонгийн гольдрол	Ашиглалт	10/14/2026	485.7
29	Бүрэгхангай	MV-000267	Ар тамсаг	Ашиглалт	4/24/2026	145.4
30	Бүрэгхангай	MV-008866	Өгөөмөр-2	Ашиглалт	12/8/2034	641.8
31	Бүрэгхангай	MV-013205	Өгөөмөр хоолой-3	Ашиглалт	12/8/2034	34.4
32	Бүрэгхангай	MV-007713	Их тохойрол-1	Ашиглалт	6/11/2034	262.4
33	Бүрэгхангай	MV-021704	Их тохойрол	Ашиглалт	6/11/2034	364.7
34	Бүрэгхангай	MV-021706	Их тохойрол	Ашиглалт	6/11/2034	195.1

35	Бүрэгхангай	MV-021708	Их тохойрол	Ашиглалт	6/11/2034	52.6
36	Бүрэгхангай	MV-000782	Туулын зүүн дэнж	Ашиглалт	10/28/2027	24.0
37	Бүрэгхангай	MV-000181	Туулын зүүн дэнжийн 1-3	Ашиглалт	4/24/2026	7.1
38	Бүрэгхангай	MV-000175	Туул голын гольдрол	Ашиглалт	8/18/2025	211.1
39	Бүрэгхангай	MV-016841	Туул голын баруун дэнж	Ашиглалт	10/4/2033	54.6
40	Бүрэгхангай	MV-008998	Баруун зах цаг	Ашиглалт	12/21/2034	252.0
41	Бүрэгхангай	MV-006680	Баруун зах цаг	Ашиглалт	12/22/2033	117.3
42	Гурванбулаг	XV-021398	Баяндүүрэх	Хайгуул	8/16/2022	413.8
43	Дашинчилэн	MV-004691	Урд дэлэн	Ашиглалт	7/29/2032	15.1
44	Орхон	XV-63000022 (ТХ-01025)	Оросын булаг	Хайгуул	11/7/2021	37.5
45	Орхон	XV-63000001	Хүрэмт	Хайгуул	3/7/2020	46.4
46	Орхон	XV-63000027 (63000027)	Орхон	Хайгуул	3/12/2023	72.2
47	Орхон	MV-003274	Бумбатын гол	Ашиглалт	5/10/2031	25.2
48	Орхон	MV-002613	Айраг уул	Ашиглалт	9/22/2030	25.7
49	Рашаант	XV-018216	Алтан хүрд	Хайгуул	4/22/2024	5249.1
50	Сайхан	XV-012738	Номгон	Хайгуул	10/29/2022	5398.8
51	Сайхан	XV-013459	Эрээний ихэр уул-2	Хайгуул	4/2/2020	527.7
52	Сайхан	MV-002366	Сайхан уул	Ашиглалт	6/9/2030	39.4
53	Сэлэнгэ	XV-63000003	Сэлэнгэ	Хайгуул	3/7/2020	84.6
54	Тэшиг	MV-001781	Цагаан шар	Ашиглалт	7/28/2029	153.4
55	Ишиг-Өндөр	XV-018555	Хад	Хайгуул	9/2/2024	5488.5
НИЙТ						54085.9



Зураг 121. Орон нутгийн тусгай хамгаалалтад авах уул, уурхайн тусгай зөвшөөрөлтэй газрын төлөвлөгөө

2.6.4. ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛЫГ АВРАН ХАМГААЛАХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх гэж заасан байдаг. Булган аймгийн хэмжээнд газар зохион

байгуулалтын хугацаанд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд өртөн устаж магад түүх, соёлын дурсгалт газруудыг тодорхойлон авран хамгаалахаар төлөвлөгөөнд тусган ажилласан.

Аймгийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Эгийн голын усан цахилгаан станцын ус хуримтлах талбайн дагуу байрлалтай түүх соёлын дурсгалт газрууд нь усан доор орж живэх эрсдэлтэй тул уг дурсгалт газруудыг авран хамгаалахаар төлөвлөсөн.

Уг газрууд нь Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутагт орших аймгийн хамгаалалт бүхий нэг, сумын хамгаалалттай гурван дурсгалт газар хамрагдаж байна.

Хүснэгт 127. Авран хамгаалах шаардлагатай түүх соёлын дурсгалт газрын төлөвлөгөө

№	Хамгаалалтын төрөл	Дурсгалт газрын төрөл	Газрын нэр	Уртраг	Өргөрөг
1	Аймгийн	Хадны зураг, бичээс	Хужир нуга	103°33'09.8"	49°25'51.9"
2	Сумын	Хадны зураг, бичээс	Бурхант толгойн	103°30'07.4"	49°26'46.4"
3	Сумын	Булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж	Шар чулуут уулын	103°15'41.3"	49°34'8.8"
4	Сумын	Эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал	Холтост нуга	103°21'49.3"	49°28'35.0"

Авран хамгаалах шаардлагатай түүх, соёлын газрын төлөвлөгөөний хэрэгжүүлэх хугацааг тооцохдоо Эгийн голын усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулах бүтээн байгуулалт эхлэхээс өмнө байхаар тооцон төлөвлөсөн.

2.6.5. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ

Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгай хэрэгцээний газрын төлөвлөгдсөн арга хэмжээг үе шатанд хуваан тусгасан. Ингэхдээ тусгагдсан арга хэмжээний орон нутгийн санал, бусад бодлогын баримт бичигт тусгагдсан байдал, цар хүрээ зэргийг харгалзан төлөвлөлтийн ойрын, дунд, урт гэж хуваан тусгасан.

Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад шинээр авах газрыг төлөвлөгөөнд тусгахдаа төлөвлөлтийн ойрын буюу 2022-2025 онуудад авахаар төлөвлөсөн. Учир нь улс болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах зорилго нь байгалийн унаган төрх, түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах тул ойрын хугацаанд хамгаалалтад авч бусад газар ашиглалтаас чөлөөлөх юм. “Зэд хантай бүтээлийн нуруу” дархан цаазат газрыг хэсэгчлэн зэрэглэл бууруулах төлөвлөлтийг оролцогч олон байгууллагын шийдвэрээс шалтгаалан хэрэгжих тул төлөвлөлтийн дунд хугацаанд төлөвлөсөн.


Уул, уурхайн ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссаны дараа орон нутгийн тусгай хамгаалалтад авах газрын төлөвлөхдөө тухайн тусгай зөвшөөрлийн дуусах хугацаатай уялдуулан төлөвлөсөн. Авран хамгаалах түүх, соёлын дурсгалт газрын төлөвлөгөөний хэрэгжүүлэх хугацааг Эгийн голын УЦС-ын станцын төслийн хэрэгжиж эхлэх хугацаан өмнө байхаар тооцон төлөвлөлтийн дунд үе шатанд байхаар тооцсон /Хүснэгт 128/.

Хүснэгт 128. Тусгай хэрэгцээний газрын төлөвлөгөөний үе шатны хуваарь

№	Сумын нэр	Хэмжих нэгж	Тайлбар	Тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөөний үе шат			Нийт
				Ойрын 2025 он	Дунд 2029 он	Урт 2034 он	
Улсын тусгай хамгаалалтад авах газар							
1	Баяннуур	га	УГЗБЕТ, орон нутгийн санал	750.0			750.0
2	Дашинчилэн	га		3,095.8			3,095.8
3	Могод	га		2,909.8			2,909.8
4	Сэлэнгэ	га			179,814.8		179,814.8
5	Тэшиг	га		15,516.5			15,516.5

**БУЛГАН АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

6	Хангал	га		12,094.6			12,094.6
7	Хутаг-Өндөр	га		3,802.2			3,802.2
НИЙТ				38,169.0	179,814.8	0.0	217,983.8
Орон нутгийн тусгай хамгаалалтад авах							
1	Баян-Агт	га	Орон нутгийн саналаар	101,484.4			101,484.4
2	Баяннуур	га		86,753.7			86,753.7
3	Бүрэгхангай	га		302,365.3			302,365.3
4	Гурванбулаг	га		12,484.6			12,484.6
5	Дашинчилэн	га		5,641.3			5,641.3
6	Могод	га		6,062.8			6,062.8
7	Орхон	га		40,753.0			40,753.0
8	Рашаант	га		8,862.0			8,862.0
9	Сайхан	га		37,896.1			37,896.1
10	Тэшиг	га		15,611.7			15,611.7
11	Хангал	га		29,555.4			29,555.4
12	Хишиг-Өндөр	га		60,877.6			60,877.6
13	Хутаг-Өндөр	га		9,582.0			9,582.0
НИЙТ				717,930.1	0.0	0.0	717,930.1
Орон нутгийн тусгай хамгаалалтад авах уул, уурхайн тусгай зөвшөөрөлтэй газрын төлөвлөгөө							
1	Баяннуур	га	Орон нутгийн саналаар	30.1	1,854.5		1,884.6
2	Бугат	га		30.1			30.1
3	Бүрэгхангай	га		29,113.0	1,752.9	3,727.9	34,593.8
4	Гурванбулаг	га		413.8			413.8
5	Дашинчилэн	га				15.1	15.1
6	Орхон	га		156.2		51.0	207.2
7	Рашаант	га			5,249.1		5,249.1
8	Сайхан	га		5,926.5		39.4	5,965.9
9	Сэлэнгэ	га		84.6			84.6
10	Тэшиг	га				153.4	153.4
11	Хишиг-Өндөр	га			5,488.5		5,488.5
НИЙТ				35,754.3	14,345.0	3,986.7	54,085.9
Авран хамгаалан түүх, соёлын дурсгалт газар							
1	Хутаг-Өндөр	Ширхэг	Орон нутгийн саналаар		4		4
НИЙТ				0	4	0	4
НИЙТ ДҮН				791,853.3	194,159.7	3,986.7	989,999.8



Зураг 122. Тусгай хэрэгцээний газрын төлөвлөгөө

2.7. ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ТӨЛӨВЛӨЛТ


Монгол улсын хууль тогтоомжуудад тодорхой газар ашиглалтын төрөл тус бүрд хамгаалалтын бүс, болон түүний мөрдөх горимууд заагдсан байдаг. Хамгаалалтын бүсэд заагдсан горимын дагуу зарим төрлийн газар ашиглалтыг хориглох, болон хязгаарлах шаардлагатай болдог. Тухайлбал Булган аймгийн газар ашиглалтын төрлүүдээр авч үзвэл усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хамгаалалтын бүс, тариалангийн газрын хамгаалалтын бүс, авто замын зурвас газар, төмөр замын хамгаалалтын бүс, эрчим хүч дамжуулах шугамын хамгаалалтын бүс, хогийн цэг, оршуулгын газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүс, түүх, соёлын дурсгалт газруудын хамгаалалтын бүсүүд багтаж байна.

Хүснэгт 129. Хамгаалалтын бүсийн төрөл, хэмжээ, үндэслэл.

№	Бүсийн төрөл	Газар ашиглалтын төрөл	Хамгаалалтын бүсийн өргөн	Үндэслэл
1	Бэлчээрт дах уст цэг	Худаг	50 метр	Кадастрын зураглалын ажил БНБД
2	Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс	Булаг	50 метр	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
		Гол	100 метр	
		Нуур	100 метр	
3	Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс	Булаг	200 метр	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
		Гол	200 метр	
		Нуур	200 метр	
4	Ойн сан бүхий газрын хамгаалалтын бүс	Ой тэлэн ургах нөөц газар	100 метр	Ойн тухай хууль
5	Тариалангийн газрын хамгаалалтын бүс	Тариалан	500 метр	Тариалангийн тухай хууль
6	Авто замын зурвас газар	Хатуу хучилттай авто зам	100 метр	Авто замын тухай хууль
		Сайжруулсан шороон зам	60 метр	
		Ердийн шороон зам	6 метр	
7	Төмөр замын хамгаалалтын бүс	Төмөр зам	60 метр	Төмөр замын аюултай бүсийн дэглэм
8	Эрчим хүч, дамжуулах шугамын хамгаалалтын бүс	1-20 кв	10 метр	Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм
		35 кв	15 метр	
		110 кв	20 метр	
9	Шилэн кабелийн хамгаалалтын бүс	Шилэн кабель	10 метр	Харилцаа холбооны тухай хууль
10	Хогийн цэгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	Хогийн цэг	300 метр	Хог хаягдлын тухай хууль
11	Оршуулгын газрын хамгаалалтын бүс	Оршуулгын газар	300 метр	Кадастрын зураглалын ажил БНБД
12	Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс	Түүх, соёлын урсгалт газар	100-300 метр	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль

Булган аймгийн хэмжээнд усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс 78.0 мян.га, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс 193.9 мян.га, бэлчээрийн уст цэгийн энгийн хамгаалалтын бүс 718.0 га, ой тэлэн ургах нөөц газар 277.7 мян.га, тариалангийн газрын хамгаалалтын бүс 131.9 мян.га, авто замын зурвас газар 18.5 мян.га, төмөр замын хамгаалалтын бүс 2171.2 га, эрчим хүч дамжуулах шугамын хамгаалалтын бүс 7473.8 га, холбоо, мэдээлэл дамжуулах шугамын хамгаалалтын бүс 1014.4 га, хогийн цэгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс 1304.9, оршуулгын газрын хамгаалалтын бүс 2412.6 га, түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс 5301.5 га газар тус тус хамаарч байна.

Хамгаалалтын бүсийг одоогийн газар ашиглалтын байдал мөн цаашид хэрэгжих төлөвлөгөөний газар ашиглалтын төрлүүдэд дүрэм журмын дагуу төлөвлөсөн. Энэ нь цаашид гарч болох эрсдэл болон төлөвлөгөөний хэрэгжилтэд хэрэгцээтэй бөгөөд хориглох хязгаарлах бүсүүдэд хориглосон газар ашиглалт үүсэхээс сэргийлж буй байдал юм.




Диаграмм 10. Нийт хамгаалалтын бүсийн газрын эзлэх хувь.

Аймгийн хэмжээнд нийт хамгаалалтын бүсийн газрын 38.5 хувийг ойн тэлэн ургах нөөц газар, 26.9 хувийг усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, 18.3 хувийг тариалангийн газрын хамгаалалтын бүс, усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс 10.8 хувийг тус тус эзэлж байна. Бусад хамгаалалтын бүсийн газрууд 0.1-2.6 хувийг эзэлж байн /Хүснэгт 130/.

Хүснэгт 130. Хамгаалалтын бүсийн эзлэх талбай, га

№	Хамгаалалтын бүс	Талбай, га	Эзлэх, %
1	Авто замын зурвас газар	18,596.9	2.6
2	Ойн тэлэн ургах нөөц газар	277,741.6	38.5
3	Оршуулгын газрын хамгаалалтын бүс	2,412.6	0.3
4	Тариалангийн газрын хамгаалалтын бүс	131,975.3	18.3
5	Төмөр замын хамгаалалтын бүс	2,171.2	0.3
6	Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс	5,301.5	0.7
7	Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс	78,094.6	10.8
8	Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс	193,953.6	26.9
9	Уст цэгийн энгийн хамгаалалтын бүс	718.0	0.1
10	Хогийн цэгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	1,304.9	0.2
11	Холбоо, мэдээлэл дамжуулах шугамын хамгаалалтын бүс	1,014.4	0.1
12	Эрчим хүч дамжуулах шугамын хамгаалалтын бүс	7,473.8	1
НИЙТ		720,758.3	100



Зураг 123. Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө

2.7.1. УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийг төлөвлөхдөө Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-д зааснаар усны эх, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор хориглох болон хязгаарлах бүсүүд тогтоох бөгөөд дараах зориулалтаар газар ашиглахыг хориглоно.

Усны эх, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны аюулаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эрх үүсвэрт хамгаалалтын бүс тогтооно. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг дотор нь онцгой хамгаалалтын бүс ба энгийн хамгаалалтын бүс гэж хоёр ангилна.

Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс

Онцгой хамгаалалтын бүсийг дараах байдлаар тогтооно:

- Гол мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт түүний эргээс усны хагалбарын хил хүртэлх зайд;
- Гол мөрөн, горхи, булаг, шандын эргээс 50 метрээс доошгүй зайд буюу түүнээс өргөн, намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргөсгөж;
- Нуур, урсцын тохируулгатай усан сангийн эргээс 100 метрээс доошгүй зайд, гол мөрөн дээр байгуулсан усан сангийн хувьд түүний эргээс тухайн гол мөрний онцгой хамгаалалтын бүсийн өргөнтэй тэнцүү хэмжээний зайд;
- Хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 100 метрээс доошгүй, үерийн хамгаалалтын далангаас 50 метрээс доошгүй зайд;
- Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд;
- Үерийн хамгаалалтын суваг, түүний хамгаалалтын далангаас 30 метр хүртэлх зайд.

Онцгой хамгаалалтын бүсэд дор дурдсанаас бусад бүх төрлийн үйл ажиллагаа явуулахыг болон зуслан, суурьшлын бүс байгуулахыг хориглоно.

- Ус хангамжийн эх үүсвэрийн байгууламж барих, ашиглах;
- Гадаргын усыг ус хангамжийн эх үүсвэрт ашиглах тохиолдолд гадаргын усыг цэвэршүүлэх байгууламж барих;
- Эргийн тохижилт хийх;
- Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, гольфоос бусад спорт тоглоомын талбай байгуулах, мод бут сөөг тарих;
- Заасан газарт мал бэлчээх;
- Хяналт-шинжилгээний цооног гаргах, хяналт-шинжилгээ явуулах.

Аймгийн хэмжээнд нийт хамгаалалтын бүсийн газрын 10.8 хувь буюу 78.0 мян.га газрын усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийн газар эзэлж байна. Булган аймаг гадаргын ус нуур, гол, мөрний сүлжээ элбэгтэй тул үүний усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийн газар их байна. Цаашид эдгээр газар ашиглалтын үйл ажиллагааг зогсоох шаардлагатай.

Хүснэгт 131. Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийн газар, сумдаар

№	Сумын нэр	Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс		Нийт хамгаалалтын бүсийн газар	
		Талбай, га	Эзлэх, %	Талбай, га	Эзлэх, %
1	Баян-Агт	5,942.5	7.6	63,409.7	9.4
2	Баяннуур	3,588.2	4.6	16,246.6	22.1

3	Бугат	4,312.7	5.5	64,097.2	6.7
4	Булган	202.4	0.3	2,127.8	9.5
5	Бүрэгхангай	5,859.5	7.5	42,306.0	13.9
6	Гурванбулаг	5,474.9	7.0	32,469.1	16.9
7	Дашинчилэн	4,806.1	6.2	23,829.3	20.2
8	Могод	6,179.0	7.9	33,604.8	18.4
9	Орхон	7,706.5	9.9	82,292.5	9.4
10	Рашаант	1,012.0	1.3	20,024.6	5.1
11	Сайхан	5,467.0	7.0	37,523.1	14.6
12	Сэлэнгэ	3,976.4	5.1	47,800.9	8.3
13	Тэшиг	6,068.9	7.8	66,637.3	9.1
14	Хангал	2,396.0	3.1	32,812.6	7.3
15	Хишиг-Өндөр	4,335.8	5.6	34,081.1	12.7
16	Хутаг-Өндөр	10,766.7	13.8	121,495.6	8.9
НИЙТ		78,094.6	100.0	720,758.3	10.8

Усны сан бүхий энгийн хамгаалалтын бүс

Энгийн хамгаалалтын бүсийн заагийг дараах байдлаар тогтооно:

- Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд;
- Нийслэл болон аймгийн төвийн хот суурины нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 500 метр хүртэлх зайд.

Энгийн хамгаалалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- Мод бут огтлох;
- Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжгүй буюу ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй барилга байгууламж барьж ашиглах
- Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис, цацраг идэвхт бодис, бүх төрлийн бордоо, пестицид хадгалах, ашиглах;
- Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах;
- Хог хаягдал, бохирдуулах бодис хаях, хог хаягдлын цэг байршуулах;
- Мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах;
- Стандартын шаардлага хангаагүй бохир усны цооног, бие засах газар барьж ашиглах.

Аймгийн хэмжээнд хамгаалалтын бүсийн газрын 26.9 хувь буюу 193.9 мян.га усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн газар эзэлж байна. Нийт усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн 16.6 хувийг Хутаг-Өндөр сум, 10.3 хувийг Орхон сум, 8.8 хувийг Могод сум, 8.2 хувийг Бүрэгхангай сум тус тус эзэлж байна. Харин бусад сумд үлдсэн хувийг хуваан эзэлж байна /Хүснэгт 132/.

Хүснэгт 132. Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн газар, сумдаар

№	Сумын нэр	Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс		Нийт хамгаалалтын бүсийн газар	
		Талбай, га	Эзлэх, %	Талбай, га	Эзлэх, %
1	Баян-Агт	14,689.8	7.6	63,409.7	23.2
2	Баяннуур	6,662.3	3.4	16,246.6	41.0
3	Бугат	10,943.0	5.6	64,097.2	17.1
4	Булган	566.7	0.3	2,127.8	26.6
5	Бүрэгхангай	15,957.4	8.2	42,306.0	37.7
6	Гурванбулаг	12,033.9	6.2	32,469.1	37.1
7	Дашинчилэн	7,098.9	3.7	23,829.3	29.8
8	Могод	17,078.9	8.8	33,604.8	50.8
9	Орхон	19,973.9	10.3	82,292.5	24.3
10	Рашаант	2,745.8	1.4	20,024.6	13.7
11	Сайхан	11,787.4	6.1	37,523.1	31.4
12	Сэлэнгэ	10,082.7	5.2	47,800.9	21.1
13	Тэшиг	14,371.5	7.4	66,637.3	21.6
14	Хангал	6,724.0	3.5	32,812.6	20.5
15	Хишиг-Өндөр	11,115.5	5.7	34,081.1	32.6

16	Хутаг-Өндөр	32,121.9	16.6	121,495.6	26.4
НИЙТ		193,953.6	100.0	720,758.3	26.9

Бэлчээрийн уст цэгийн энгийн хамгаалалтын бүс

Булган аймгийн бэлчээрийн усан хангамжид гадаргын ус голлох хувийг эзлэх боловч гадаргын ус татарсан өвөл, хаврын улиралд бэлчээрийн уст чухал ач холбогдолтой байна. Аймгийн хэмжээнд Булган сумдаас бусад сумдад бэлчээрийн уст цэгийн энгийн хамгаалалтын бүсийг татан ажилласан.

Бэлчээрийн уст цэгийн энгийн хамгаалалтын бүсийг төлөвлөхдөө “кадастрын зураглалын ажил БНБД 11-11-16”-д хэмжилт хийсэн уст цэгийн эргэн тойрондох нэг га газрыг хамгаалалтын бүсийн хилээр нэгж талбарыг тодорхойлно гэж заасны дагуу зурагласан.

Бэлчээрийн уст цэгийн энгийн хамгаалалтын бүсэд усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг хэрэгжүүлнэ. Булган аймгийн хэмжээнд нийт хамгаалалтын бүсийн газрын 0.1 хувь буюу 718.0 га газар бэлчээрийн уст цэгийн энгийн хамгаалалтын бүсийн газар байна.

Хүснэгт 133. Бэлчээрийн уст цэгийн энгийн хамгаалалтын бүс, сумдаар

№	Сумын нэр	Бэлчээрийн уст цэгийн энгийн хамгаалалтын бүс		Нийт хамгаалалтын бүсийн газар	
		Талбай, га	Эзлэх, %	Талбай, хувь	Эзлэх хувь
1	Баян-Агт	90.8	12.7	63,409.7	0.14
2	Баяннуур	47.4	6.6	16,246.6	0.29
3	Бугат	46	6.4	64,097.2	0.07
4	Бүрэгхангай	56.8	7.9	42,306.0	0.12
5	Гурванбулаг	51.5	7.2	32,469.1	0.2
6	Дашинчилэн	63.4	8.8	23,829.3	0.26
7	Могод	62.2	8.7	33,604.8	0.21
8	Орхон	70.7	9.8	82,292.5	0.05
9	Рашаант	40.2	5.6	20,024.6	0.25
10	Сайхан	49.2	6.8	37,523.1	0.01
11	Сэлэнгэ	3.6	0.5	47,800.9	0.04
12	Тэшиг	20.1	2.8	66,637.3	0.04
13	Хангал	29.6	4.1	32,812.6	0.14
14	Хишиг-Өндөр	46.1	6.4	34,081.1	0.12
15	Хутаг-Өндөр	40.4	5.6	121,495.6	0.59
НИЙТ		718	100	718,630.5	0.1

2.7.2. ЗАМ, ШУГАМ, СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮС

Авто замын зурвас газар. Монгол улсын Авто замын тухай хуульд авто замын зурвас газар гэж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулах, цаашид авто замыг өргөтгөх зориулалтаар тогтоосон газрыг хэлнэ гэж заасан байдаг.

Авто замын тухай хуулийн 16.2 заалтад авто замын зурвасыг Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газрын өргөн 100 метр /замын тэнхлэгээс хоёр тийш 50 метр/, орон нутгийн чанартай авто замын зурвас газрын өргөн 60 метр /замын тэнхлэгээс хоёр тийш 30 метр/ гэж заасан. Мөн Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнээс эрх олгосон этгээд байна гэж авто тээврийн тухай хуулийн 17.3 заалтад тодорхой заасан байдаг.

Авто замын зурвас газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: Үүнд

- Хог хаях, ус урсгах, төмөр, чулуу зэрэг зүйлс үлдээх
- Хөдөлгөөнд саад учруулж, үзэгдэх орчин хязгаарласан хаяг, сурталчилгааны самбар, эд зүйл байршуулах

- Зурвас газарт авто замын ашиглалттай холбоогүй болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхлэх

Булган аймгийн авто замын зурвас газрыг төлөвлөхдөө одоо ашиглагдаж байгаа болон цаашид барьж байгуулах авто замуудыг хамруулан төлөвлөсөн. Аймгийн хэмжээнд авто замын зурвас газарт 18.5 мян.га газар хамарч байна.

Хүснэгт 134. Авто замын зурвас газар

№	Сумын нэр	Авто замын зурвас газар		Нийт хамгаалалтын бүсийн газар	
		Талбай, га	Эзлэх, %	Талбай, га	Эзлэх, %
1	Баян-Агт	1,050.9	5.7	63,409.7	1.7
2	Баяннуур	271.4	1.5	16,246.6	1.7
3	Бугат	1,474.2	7.9	64,097.2	2.3
4	Булган	144.1	0.8	2,127.8	6.8
5	Бүрэгхангай	1,689.6	9.1	42,306.0	4
6	Гурванбулаг	1,376.0	7.4	32,469.1	4.2
7	Дашинчилэн	1,030.5	5.5	23,829.3	4.3
8	Могод	940.1	5.1	33,604.8	2.8
9	Орхон	1,722.3	9.3	82,292.5	2.1
10	Рашаант	546.1	2.9	20,024.6	2.7
11	Сайхан	1,354.8	7.3	37,523.1	3.6
12	Сэлэнгэ	1,529.3	8.2	47,800.9	3.2
13	Тэшиг	1,427.4	7.7	66,637.3	2.1
14	Хангал	646.0	3.5	32,812.6	2
15	Хишиг-Өндөр	1,256.1	6.8	34,081.1	3.7
16	Хутаг-Өндөр	2,137.7	11.5	121,495.6	1.8
НИЙТ		18,596.9	100	720,758.3	2.6

Холбоо, мэдээлэл дамжуулах шугамын хамгаалалтын бүс. “Харилцаа, холбооны тухай хууль”-д Монгол Улсын газрын нэгдмэл сангаас холбооны сүлжээнд зориулан олгосон газар, орон зайг харилцаа холбооны хамгаалалтын зурвас гэнэ. Хамгаалалтын зурвас газар нь дараах хэмжээтэй байна:

- Агаарын баганат шугамаас тал бүрдээ 10 метр
- Кабелийн шугамаас тал бүрдээ 5 метр
- Радио релейн шугамын станц хоорондын буюу сансрын холбооны хиймэл дагуулын газрын нэвтрүүлэх станцын долгион цацалтын орон зай, тухайн станцаас тал бүрдээ 300 метр голчтой
- Радио, телевизийн нэвтрүүлэх станцын болон долгион үүсгэх тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааруулан тогтоосон эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ.

Харилцаа холбооны хамгаалалтын зурвас газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- Барилга, гэр, хашаа барих, мод тарих;
- Кабель гэмтээж болох зүйл хаях, химийн идэмхий бодис асгах;
- Зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр ачаатай тээврийн хэрэгслээр агаарын баганат шугамыг хөндлөн гарах.

Аймгийн хэмжээнд холбоо, мэдээлэл дамжуулах шугамын хамгаалалтын бүсийн газар нийт хамгаалалтын бүсийн газрын 2.6 хувь буюу 18.5 мян.га хамрагдаж байна.

Хүснэгт 135. Холбоо харилцааны шугамын хамгаалалтын бүс

№	Сумын нэр	Холбоо, мэдээлэл дамжуулах шугамын хамгаалалтын бүс		Нийт хамгаалалтын бүсийн газар	
		Талбай, га	Эзлэх, %	Талбай, га	Эзлэх, %
1	Баян-Агт	17.5	1.7	63,409.7	0.03
2	Баяннуур	4.6	0.4	16,246.6	0.03
3	Бугат	114.8	11.3	64,097.2	0.18
4	Булган	17.4	1.7	2,127.8	0.82
5	Бүрэгхангай	52.7	5.2	42,306.0	0.12

6	Гурванбулаг	81.2	8	32,469.1	0.25
7	Дашинчилэн	63.1	6.2	23,829.3	0.26
8	Могод	67.4	6.6	33,604.8	0.2
9	Орхон	101.7	10	82,292.5	0.12
10	Рашаант	59.5	5.9	20,024.6	0.3
11	Сайхан	49.0	4.8	37,523.1	0.13
12	Сэлэнгэ	22.2	2.2	47,800.9	0.05
13	Тэшиг	18.1	1.8	66,637.3	0.03
14	Хангал	53.1	5.2	32,812.6	0.16
15	Хишиг-Өндөр	149.9	14.8	34,081.1	0.44
16	Хутаг-Өндөр	142.2	14	121,495.6	0.12

